

## **ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

### **Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:**

МҮЭХ-ны эв санааны нэгдлийн цуглаанаас Засгийн газарт ирүүлсэн шаардлагыг “Цалин хөлсний асуудлаар зөвлөлдөх гурван талт салбар хороо”, улмаар “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо”-ны хурлуудаар тус тус хэлэлцэн зохих шийдвэр гаргаж талууд зөвшилцөн ажиллаж байна. Үндэсний хорооны хуралдааны шийдвэр болон МҮЭХ-ны шаардлагад тусгагдсан “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах тухай”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад талуудын саналыг тусгах, өөрийн оронд шингэн түлш гаргах үйлдвэрүүдийг барьж байгуулах, 40 мянган орон сууц хөтөлбөрийг эрчимжүүлэх, алслагдсан болон хязгаар нутагт бүсийн нэмэгдэл олгох зэрэг асуудлуудыг шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яамдад хүргүүлэн зохих арга хэмжээ авч байна.

“Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гурван талт ажлын хэсгийг байгуулан салбарын түвшинд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ялгавартайгаар тогтоох тухай асуудлыг судалж эхлээд байна. Улмаар цалин хөлсний бодлогыг нэг удаагийн нэмэгдлээр хязгаарлахгүйгээр үндэслэл бүхий суурь судалгаанд тулгуурласан цалингийн шинэчлэлийг гурван талын зөвшилцлийн хүрээнд хийх болно.

“Зохистой хөдөлмөрийн төлөөх үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө” /2005-2008 он/-ний эхний шатны хэрэгжилтийн байдлыг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээллийг үндэслэн дүгнэж байна. Хэрэгжилтийн байдлыг нэгтгэх, дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөх, энэ чиглэлээр ОУХБ-тай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөлд санал авах, үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх ажлын бэлтгэл хийгдээд байна.

Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 170 дугаар зарлиг, Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 36 дугаар тэмдэглэл, Засгийн газрын 2007 оны “Ахмад дайчдын орон сууцны тухай” 250 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Ахмад дайчдын судалгааг Батлан хамгаалах яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон Монголын ахмадын холбооноос гаргуулан нэгтгэлээ.

Энэ онд 1940-1948 оны Баруун хилийн тулгаралтын 60 жилийн ой, 2009 онд 1939 оны Халх голын байлдааны ялалтын 70 жилийн ой, 2010 онд 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 65 жилийн түүхт ой, тэмдэглэлт үйл явдал болж байгаатай холбогдуулан ахмад дайчдад нэг удаа мөнгөн тусламж олгоход 1.9 тэрбум төгрөг шаардагдах тооцоо, судалгааг хийж, ахмад дайчдад орон сууц олгохтой холбогдсон 63.5 тэрбум төгрөгийг 2009 оны төсөвт тусгуулах саналын хамтын Сангийн яаманд хүргүүлэв.

Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа асруулагчдын ахуй байдлыг сайжруулах үүднээс “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх заалт, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд болон Сангийн сайдын 2008 оны 80/256 дугаар хамтарсан тушаалд тус тус заасны дагуу Улсын 8 асрамжийн газарт асруулж байгаа 350 асруулагчийн хоол, хувцас, эм, ариун цэвэр, хичээлийн хэрэглэл болон оршуулгын зардалд 718.9 сая төгрөгийг нэмж тусгах шаардлагатай тооцоо судалгааг хийж, Сангийн яаманд хүргүүлээд байна.

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ” гэж заасан. Гэвч нийгмийн халамжийн үйлчилгээг хариуцсан орон тооны ажилтан нийт сумдын 79.4 хувьд, нийслэлийн хороодын 32.5 хувьд нь байхгүй байна. Сумдын ЗДТГ-ын нийгмийн бодлогын түшмэл нь боловсрол, соёл, эрүүл мэнд, иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурал, байгаль орчин зэрэг олон асуудлуудын хавсрага байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж байна.

Иймд “Нийгмийн халамжийн тухай” хуульд заасны дагуу үлдсэн 270 сум, 43 хороонд орон тооны нийгмийн ажилтныг ажиллуулж төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх, хуулийн дагуу олгогдох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээг анхан шатанд иргэдэд хүнд сурталгүй, хөнгөн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Нийгмийн ажилтны цалингийн санг нэмж тусгахын зэрэгцээ “Төрийн албаны тухай” хуулийн дагуу тухайн ажилтны ажиллах нөхцөлийг хангах, техник тоног төхөөрөмж, бусад үйл ажиллагааны зардлыг 2009 оны төсөвт тусгуулахаар холбогдох тооцоо судалгааг хийж Сангийн яаманд хүргүүлээ.

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн 6.9, Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолд заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж,

мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж, ажилтан ажиллуулахаар заасны дагуу 5 орон тоо, 21 аймаг, 9 дүүргийн хэлтэс тус бүрд 30 орон тоо нийт 35 орон тоог нэмүүлэхээр холбогдох тооцоог хийж Сангийн яаманд 2008 оны 6 сарын 19-нд 3/1226 тоот албан бичиг хүргүүлсэн. 2008 оны хувьд төсвийн тодотгол хийгдээгүй байгаатай холбогдуулан эдгээр ажиллагсдыг 2009 оны 1 дүгээр сараас эхлэн ажиллуулах саналыг Сангийн яамны зүгээс тавьж холбогдох тооцоог дахин хийж тус яамнаас дээрх 35 орон тоотой холбогдох 155.6 сая төгрөгийг 2009 оны төсөвт тусгуулахаар дахин хүргүүлээд байна. Ингэснээр нийгмийн халамжийн арга хэмжээнд зориулан зарцуулж байгаа төсвийн 270 орчим тэрбум төгрөгийн ашиглалт, зарцуулалт, бичиг баримт бүрдүүлэлт, тусламж эзэндээ хүрч буй эсэх зэрэгт дотоод хяналт тавьж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах юм.

“Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх” тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300 мянган төгрөгийг нэг удаа олгох заалт нэмэхээр холбогдох тооцоо судалгаа хийх, танилцуулга, үзэл баримтлал боловсруулах ажлыг эхлээд байна.

УИХ-ын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 21 тоот тогтоолыг шинэчлэн “Мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж байна.

Алдарт эх-II одонтой эхэд 500 мянган төгрөг, Алдарт эх-I одонтой эхэд 1 сая төгрөгийн тэтгэмжийг жил бүр олгоно гэж заасны дагуу УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, үзэл баримтлал, холбогдох тооцоо, судалгааг хийж байна.

“Хүн амын шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, үр дагавар, чиг хандлага” сэдэвт судалгааны туршилтын судалгааг Төв аймгийн Эрдэнэ сум, нийслэлийн Сонгинохайрхан, Багануур дүүрэгт зохион байгууллаа. Туршилтын судалгаагаар мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болон түүвэрлэлтийн нэгжийг сонгох аргачлалыг шалган, холбогдох алдааг засан, судалгааны Удирдах зөвлөлийн хурлаар батлууллаа. Удирдах зөвлөлөөс мэдээлэл цуглуулах ажлыг 2008 оны 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэв.

Хүн амын хөгжлийн асуудал хариуцсан Үндэсний зөвлөл хороо бусад улс оронд хэрхэн ажиллаж буй туршлагыг судлах ажлыг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд Этиоп орны бүтэц, хамтран ажиллагч байгууллагын үүрэг оролцоог судалсан болно.

Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих Зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгуулав.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хорооны ээлжит хуралдаан болох гэж байгаатай холбогдуулан манай улсаас өмнө хүргүүлсэн 5 дугаар тайлантай холбоотой 28 нэмэлт асуулыг Засгийн газарт ирүүлээд байгаа бөгөөд түүнд хариу бэлтгэн хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Гадаад гэрлэлт, БНСУ-ын иргэдтэй гэрлэж буй эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалал, холбогдох хууль тогтоомж, шийдвэрлэх арга замын талаар зохион байгуулсан сургалт, семинарт Төрөөс гэр бүлийн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаар илтгэл бэлтгэж хэлэлцүүлээ. Тус зөвлөгөөнөөр эмэгтэйчүүдийн гадаад иргэд, ялангуяа солонгос эрэгтэйчүүдтэй гэр бүл болж буй шалтгаан, хоёр улсын гадаад гэрлэлтийн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцлээ.

“Нийгмийн халамжийн сан болон Монгол Улсыг хөгжүүлэх сангаас олгож буй мөнгөн тэтгэмжүүд өрхийн аж байдалд ямар нөлөө үзүүлж байгааг судлах” судалгааны асуулгыг боловсруулаад байна. Энэ нь нийтлэг олгогдож буй мөнгөн тусламж /хүүхдийн хөгжлийн мөнгө, шинэ гэр бүлийн мөнгө, шинэ төрсөн хүүхдийн мөнгө, алдарт эхчүүдэд олгож байгаа мөнгөн тусламж г.м/-уудын өрхийн амьжиргаанд үзүүлж буй дэмжлэг, тухайн бодлого, хөтөлбөрийн эцсийн зорилтыг хангаж буй байдал болон үр өгөөжид үнэлэлт өгөх зорилготой юм. Мөн халамж тусламжийн зардал хэт их байна гэсэн шүүмжлэлд судалгаа, шинжилгээний үндэслэлтэй хариулыг өгнө гэж үзэж байна.

ОУХБ-ын төлөөлөгчдийн оролцоотойгоор “Цалингийн судалгааны талаарх Зөвлөлдөх уулзалт” зохион байгуулав. Энэхүү уулзалтаар Нийгмийн түншүүдийн цалингийн талаарх мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, цалингийн судалгааны агуулга энэ хэрэгцээг хангаж чадах эсэх талаар санал солилцон нэгдсэн дүгнэлтэнд хүрлээ.

НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисст манай Засгийн газар хандаж хүсэлт тавьсны дагуу тус комиссын ажлын баг Монгол Улсад 9 дүгээр сарын 2-9-ний өдрүүдэд айлчлал хийв. Ажлын баг ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх, түүнээс олж байгаа ашиг орлогыг улс орны тулгамдсан асуудалд зүй зохистой чиглүүлэх асуудлаар судалгаа хийж, бодлого боловсруулахад туслалцаа үзүүлэх зорилготой ирсэн болно. Төлөөлөгчид Үйлдвэр худалдааны яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, АМГТХЭГ, Үндэсний статистикийн газрын холбогдох хүмүүстэй уулзаж, судалгааны эхний шатны мэдээлэл авсан. Ажлын багийн судалгаа, зөвлөмж, олон улсын туршлага нь манай улсын уул уурхайн зөв бодлого, хөгжил, эх орны хишиг сангийн ажилд чухал ач холбогдолтой байх болно.

Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг энэ оны 4 дүгээр улиралд Улаанбаатар хотноо хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан Иргэд харилцан хөдөлмөр эрхлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг тохиролцох, Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай саналыг Гадаад хэргийн яаманд хүргүүлэв.

БНСУ-ын Хөдөлмөрийн яамтай байгуулах “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу БНСУ-д ажилчид илгээх тухай” Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг тусган монгол орчуулгыг эцэслэн боловсруулав. Монгол, Солонгосын Хөдөлмөрийн Яамд хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, хоёр тал Солонгос хэлний шалгалттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэж, шинэчлэн байгуулж буй Санамж бичигт тусгахаар тохиролцоонд хүрсэн болно.

**Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:** Тайлант хугацаанд Халамжийн тэтгэвэрт нийт **48487** иргэн хамрагдаж тэдэнд **14096.5** сая төгрөгийг олгосон байна.

**Нөхцөлт мөнгөн тэтгэмж :**

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа 9007 иргэнд 1204.8 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 6430 иргэнд 845.8 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 1509 иргэнд 180.7 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа 509 хүнд 74.5 сая төгрөг,
- Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа 383 хүнд 71.5 сая төгрөг,
- Хүүхэд, төрөл садангүй, ганц бие Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа 92 иргэнд 4.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

**Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ :** Үүнд нийт **9721** иргэн хамрагдаж тэдэнд **772.6** сая төгрөгийг олгосон байна.

- Зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулахад 2470 иргэн хамрагдаж 43.8 сая төгрөг,
- Хөдөлмөр эрхэлж, орлогын эх үүсвэртэй болгоход нь туслах зорилгоор 842 иргэнийг хамруулж 70.6 сая төгрөг,
- Сэргээн засах үйлчилгээнд 2224 иргэн хамрагдаж 150.2 сая төгрөг,
- Түр байршуулан асрамжлах үйлчилгээнд 1429 иргэнийг хамруулж 101.5 сая төгрөг,
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 1588 иргэнийг хамруулж 328.4 сая төгрөг,
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж авч байгаа асаргаа, сувилгаа үзүүлж байгаа иргэдэд зориулсан сургалтанд 1168 иргэнийг хамруулж 78.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж :** Үүнд 4440 иргэн хамрагдаж 519.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлтөнд 1440 хүүхдэд 37.0 сая төгрөг,
- 3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа олгодог тэтгэмжинд 154 хүүхэд хамрагдаж 11.1 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа олгодог тэтгэмжинд 2107 иргэнийг хамруулж 135.5 сая төгрөг,
- 3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа олгодог тэтгэмжинд 185 иргэнийг хамруулж 7.5 сая төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа олгодог тэтгэмжинд 159 иргэн хамрагдаж 57.0 сая төгрөг,
- Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа олгодог тэтгэмжинд 395 өрхөд 270.9 сая төгрөгийг тус тус олгосон байна.

**Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт :**

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 944427 хүүхдэд 22458.3 сая төгрөг,
- Шинээр төрсөн 39503 хүүхдэд 3950.3 сая төгрөг,
- Шинээр гэр бүл болсон 21864 өрхөд 10932.0 сая төгрөг,
- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 86296 эхчүүдэд 10819.9 сая төгрөг,
- Алдар цолтой 4740 ахмадуудад 639.2 сая төгрөг,
- Алдарт эхийн одонтой 130884 эхчүүдэд 8469.5 сая төгрөг,

- Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын ба гавъяат цолтнуудад төрөөс олгосон нэмэгдэл /Цэргийн тэтгэвэр/ -д 5327 иргэн хамрагдаж 5337.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

**Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал.** Тайлант хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 31.2 мянга, ажилгүйдлийн түвшин 3.0 хувь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 675 хүнээр, ажилгүйдлийн түвшин 0.1 хувиар буурсан байна.

Ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг 2008 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар авч үзвэл нийт 38189 ажилгүй иргэд шинээр бүртгүүлж, бүртгэлээс 36400 хасагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 1314 хүнээр, бүртгэлээс хасагдсан ажилгүй иргэдийн тоо 3881 хүнээр тус тус буурсан байна.

Тайлант хугацаанд ажил хайгчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж нийт 30.9 мянган ажилгүй иргэдийг хамруулсан байна. 2008 оны эхний 8 сард нийт 29530 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3508 хүнээр буюу 10.6 пунктээр буурсан байна.

Тайлангийн хугацаанд ажил олгогчдоос нийт 32668 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 9015-аар буюу 21.6 пунктээр буурсан байна.

2008 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар нийт 10630 ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2579-өөр буюу 19.5 пунктээр буурсан байна. Мөн 8156 ажилгүй иргэдийг нийтийг хамарсан зохион байгуулалттай ажилд хамруулж, түр ажлын байраар хангаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү ажилд 871.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **Боловсролын салбарт:**

Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх гарааны жил болсноороо энэ хичээлийн жил онцлог юм. Улсын төсөв, “Дэлхийн зөн” байгууллагын санхүүжилтээр 501 бүлэгт сурагчийн болон багшийн ширээ, сандал, самбар үзэгний хамт, “Үр дүнд түргэн хүрэх түншлэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 466 бүлэгт сурагчийн болон багшийн ширээ, сандал, самбар үзэгний хамт нийлүүлснээр улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 6 настай нэгдүгээр ангийн бүх бүлгийг ширээ, сандлаар хангалаа. Энэ хичээлийн жилд 6 настай 36.8 мянга, 7 настай 24.2 мянган хүүхэд 1 дүгээр ангид элсэн орсон байна.

Багшлах эрхийн үнэмлэх олгох журмын дагуу Боловсролын газар, орон нутгаас ирүүлсэн баримт бичгийг хянаж, ерөнхий боловсролын сургуулийн 500 багшид багшлах эрхийн үнэмлэх олголоо.

Шинээр болон шинэчлэн хэвлэсэн 10 нэрийн сурах бичгийг аймгийн Боловсрол, соёлын газар, дүүргийн Боловсролын хэлтсээр дамжуулан сургуулиудын номын санд бүрэн хүргүүлээд байна. Сурагч бүр хичээл бүрээр сурах бичигтэй байх шаардлагын хүрээнд эцэг, эхчүүдэд хандан хүүхэддээ “Хүүхдийн мөнгө”-өөр сурах бичгийг нь авч өгөхийг уриалсан сурталчилгааг 5 FM радиогоор дамжуулан олон нийтэд сурталчиллаа.

Казак хэл дээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн “Эх хэл” сурах бичгийг шинээр зохиож, монгол хэл дээр бэлтгэсэн “Математик”, “Бэлтгэл хөтөлбөр”, “Дүрслэх урлаг, технологи”, “Хөгжим”, “Хүн орчин” хичээлийн дасгал ажлын ном, сурах бичгийг казак хэл рүү орчуулан хэвлэж, Баян-Өлгий аймгийн сургуулиуд болон Ховд аймгийн Ховд сумын сургуульд хүргүүлэн сургалтад ашиглаж эхлээд байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн хичээлийн сургалтын агуулга, чанарыг сайжруулахаар 4 дүгээр ангийн дуу хөгжмийн хичээлийн шинэ хөтөлбөрийг 2008 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн нэг жилийн хугацаанд турших ажлыг Япон Улсын Монгол дахь төлөөлөгчийн газар болон “Ямаха” корпорацитай хамтран хэрэгжүүлж эхэллээ.

Туршилтад Улаанбаатар хотын 9 сургуулиас гадна 21 аймаг тус бүрээс нэг сургууль хамрагдах бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бүх нийтийн хөгжмийн боловсролын чиг хандлагад эерэг өөрчлөлт гарч, сурагчид үлээвэр хөгжмийн зэмсгээр хөгжимдөж, нот унших, бичих чадвартай болохоос гадна бусад ангийн дуу хөгжмийн хичээлийн шинэ хөтөлбөрийг боловсруулах боломжтой болох юм.

Засгийн газрын 2008 оны 316 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулж, сургалтын байгууллага, багш нарт сурталчлахын сацуу энэ онд батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийг Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр 5000 хувь хэвлэж, аймаг, нийслэлийн багш нарт хүргүүлэв.

Засгийн газрын 2008 оны 293 дугаар тогтоолоор “Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах Үндэсний хөтөлбөр 2008-2020”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхэллээ. Хөтөлбөр хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний сургалтын чанарыг олон улсын жишигт хүргэх зорилт биелэх болно.

“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, зөөврийн компьютерийн сургалтын хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 471 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 8 үндсэн гол зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2015 он гэхэд ерөнхий боловсролын сургуулиудыг шилэн кабелийн өндөр хурдны интернетиин сүлжээнд холбох, ашиглалт, үйлчилгээний зардлыг төрөөс хариуцаг болох, боловсролын үйлчилгээний цахим тогтолцоог бий болгохоороо хөтөлбөр нь ач холбогдолтой юм. Батлагдсан хуваарийн дагуу Улаанбаатар хотод 12,8 мянган, хөдөө, орон нутагт 6,9 мянган компьютерийг түгээнэ.

“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн нэгжтэй хамтран мэдээлэл, холбооны технологийг сургалтад нэвтрүүлэхэд багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын электрон хэрэглэгдэхүүн бий болгохоор ерөнхий боловсролын сургалтанд ашиглах цахим сургалтын материал боловсруулж, эхний 6 загвар хичээлийг [www.laptop.gov.mn](http://www.laptop.gov.mn) website-д байршууллаа.

“Мэргэжлийн сургалттай Спортын сургууль байгуулах тухай” асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 474 дүгээр тушаалаар шийдвэрлэлээ. Сургуулийг Спортын төв ордны материаллаг баазыг түшиглэн байгуулах бөгөөд энэ чиглэлийн сургалттай гадаад, дотоодын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн жилийн бүтцийг судлах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нийцүүлэн хянах, багшлах боловсон хүчний судалгаа хийхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгон ажиллаж байна.

“Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам”, “Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам”, “Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлуулж, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Дээрх тогтоолыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2008 оны 450/317 дугаар хамтарсан тушаалаар магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад 2008-2009 оны хичээлийн жилд сургалтын зардлыг Сургалтын төрийн сангийн зээлээр болон төрөөс хариуцан буцалтгүй тусламжаар олгох шинээр элсэгчдийн хяналтын тоог баталлаа. Үүний дагуу 2008-2009 оны хичээлийн жилд нийт магадлан итгэмжлэгдсэн 95 их, дээд сургууль, коллежийн 6200 оюутанд сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж олгоно.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын “Оюутны тэтгэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2008 оны 451/318 дугаар хамтарсан тушаалаар дээд боловсрол эзэмшүүлэхэд олгох зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хэмжээ, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага болон гадаадаас Монгол Улсад суралцагчдад олгох тэтгэлгийн хэмжээг тус тус баталлаа. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу амьжиргааны тэтгэлэггүйгээр ОХУ-д суралцагчдад сар бүр 100 ам.доллар, Польш, Унгар улсад /В ангилал/ суралцагчдад 200 ам.доллар, гадаадаас манай улсад суралцагчдад сар бүр 63 ам.доллар олгохоор шийдвэрлэлээ.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаар мэргэжилтэн бэлтгэхэд баримтлах мэргэжлийн чиглэл, төрийн өмчийн Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаар мэргэжилтэн бэлтгэхэд шаардлагатай шинээр бий болгох, шинэчлэх лаборатори, дадлагын газрын нэрсийг хангайн, баруун, зүүн, төвийн, говийн, Улаанбаатарын гэсэн 6 бүс тус бүрээр боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 461 дүгээр тушаалаар батлан мөрдөж эхэллээ. Уг чиглэлийг батласнаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг захиалагчийн /ажил олгогчийн/ эрэлт хэрэгцээ, зах зээлийн шаардлагад нийцүүлэх, зарим сургуулийн мэргэжлийн давхардлыг арилгах, хөрөнгө оруулалтыг оновчтой болгоход ач холбогдолтой юм.

Соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, албан хаагчдад зориулсан “Соёл, урлагийн маркетингийн бодлого, төлөвлөлт” сэдэвт сургалт-семинарыг АНУ-ын Сиетл хотын дуурийн театр, Монголын маркетингийн холбоотой хамтран 9 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Сургалтад 21 аймгийн номын сан, музей, театр, чуулгын дарга, захирал, төвийн мэргэжлийн урлагийн 16 байгууллагын удирдах албан тушаалтан, маркетингийн менежерүүд, хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 120 гаруй хүн хамрагдлаа.

“Шинжлэх ухаан, технологийн тухай” хууль, Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн хуралдаанаар биотехнологи, нанотехнологийн судалгааны төслүүдийг хэлэлцүүллээ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 449 дүгээр тушаалаар 2008, 2009 оноос эхлэн шинэ үеийн биотехнологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, түүний нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор 22 судалгааны төсөл, биотехнологийн судалгаа, сургалтын чадавхыг сайжруулж, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, бизнест нэвтрүүлэх орчин бүрдүүлэх зорилгоор 13, хүрээлэн буй орчны бохирдолт, нано-бүтцэт энергийн шинэ үүсгүүр, анагаах ухаан, эм зүй, эрүүл мэндийн салбаруудад нанотехнологийн судалгааг хөгжүүлэхээр 12, нано-бүтцэт материалын судалгааны үр дүнг уул уурхайн салбараас үүдэлтэй агаарын бохирдлыг арилгах, барилга, хот

байгуулалт, дэд бүтцийн салбарт нэвтрүүлэх чиглэлээр 14 судалгааны төслийг тус тус хэрэгжүүлэхээр батлан хэрэгжүүлж эхэллээ. Эдгээр төсөлд нийт 17634,16 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн болно.

Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн 10 жилийн ойд зориулсан “Нүүдлийн ба суурин соёл иргэншлийн зохицол” сэдэвт олон улсын хурлыг 9 дүгээр сарын 10-13-ны хооронд зохион байгуулж гадаадын 40 орны эрдэмтэд оролцлоо.

Монгол Улсын ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Байгалийн нөөцийн хүрээлэнтэй хамтран 9 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд “Байгаль нуурын орчмын эко-системийн өөрчлөлт, даяаршлын ба бүс нутгийн онцлог” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

### **Эрүүл мэндийн салбарт:**

Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд 2008 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр, Нээлттэй сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 191 дүгээр тушаалаар Улаанбаатар хотын эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь, төслийн техникийн ажлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын зөвлөлийн ажил үүргийн хуваарийг тус тус баталж, төсөл хэрэгжүүлэх нэгжийг 2008 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэхийг төслийн Удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

Эх, хүүхдийн бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 190 дүгээр тушаалаар Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн зөвлөмж хэмжээ, хэрэглэх зааврыг баталж, бэлдмэлийг бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл эхчүүдэд хэрэглэх талаар эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгааг зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн бодлого төлөвлөлтийн газарт даалгалаа.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 193 дугаар тушаалаар Дэлхийн зөн олон улсын байгууллагаас олгож байгаа 498,9 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, ХӨСҮТ-д хуваарилан олголоо.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 196 дугаар тушаалаар Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд “Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбоо” төрийн бус байгууллагыг нэмж оруулан, Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 197 дугаар тушаалаар Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Төв аймгийн болон Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэг, Энэрэл, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн эмнэлэгт KZ-6490 маркийн автомашиныг тус тус хуваарилан олгов.

Засгийн газрын 2008 оны 197 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 200 дугаар тушаалаар Монголын оюутны спортын II их наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг баталж, Их наадмыг 2009 оны эхний хагаст багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн дэд сайд бөгөөд Зохион байгуулах хорооны даргад үүрэг болголоо.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 210 дугаар тушаалаар “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжих Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталж, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг холбогдох албан тушаалтнуудад даалгав.

“Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний 3 дахь хөтөлбөр, “Эхийн эндэгдлийг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 211 дүгээр тушаалаар “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт сурталчилгааны удирдамж”-ийг баталж, удирдамжийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөл байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд үүрэг болгожээ.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 212 дугаар тушаалаар “Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж, түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах, тэдгээрт хяналт тавих журам”-ыг баталж, хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд үнэлгээ тогтмол хийж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн дарга, захирал нарт даалгалаа.

Засгийн газрын “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний гурав дахь хөтөлбөр батлах тухай 2007 оны 52 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 213 дугаар тушаалаар НҮБ-ын Хүн амын сангийн төв байгууллагаас 2007 онд олгосон нэмэлт санхүүжилтийн хүрээнд захиалан авсан 8 автомашиныг Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад олгож,

автомашиныг байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд авч зориулалтын дагуу ашиглахыг холбогдох аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгав.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 214 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” төслийн сугамаар нийлүүлсэн 764.9 сая төгрөгийн, 2008 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хавдар судлалын үндэсний төвд олгох 2.0 сая төгрөгийн, Халдварт өвчин судлалын төвд олгох 103.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хуваарийг тус тус баталж, олгосон эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, зориулалтын дагуу ашиглахыг эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгов.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 217 дугаар тушаалаар Бээжингийн 2008 оны зуны олимп болон паралимпийн амжилтыг дүгнэх, цаашид олимпын бэлтгэл хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох, тамирчид болон тэдгээрийн бэлтгэлийг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор “Олимпын сургамж, биеийн тамир, спортын талаар цаашид тавих зорилт” сэдэвт үндэсний хэмжээний тайлангийн хурал зохион байгуулж, илтгэл бэлтгэх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, илтгэлийг энэ оны 10 дугаар сарын 10-ны дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болгохыг Эрүүл мэндийн дэд сайдад үүрэг болгов.

**Шуурхай мэдээлэл.** Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд хийсэн үнэлгээ. Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 209 дүгээр тушаалаар Дархлаажуулалтын 10 хоногийг “Менингококкт халдвараас сэргийлье” уриан дор энэ оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн зохион байгуулж, энэ үеэр менингококкт халдварын өвчлөл өндөр байгаа Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Булган аймгийн төв, Орхон, Дархан-Уул, Улаанбаатар хотын 2-10 насны хүүхдийг менингококкт халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээ зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв, тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгав. Мөн бусад аймгийн заавал дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулахыг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгаж, дархлаажуулалтын 10 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөө, менингококкт халдварын эсрэг вакцин, зүү, тариур, аюулгүй хайрцаг, вакцин тарих заавар, мэдээний хүснэгт, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг судлах асуумжийг тус тус баталж, вакцин тариулсан хүүхдийн нас тус бүрээс 10 хүүхдийг санамсаргүй түүвэр судалгааны аргаар сонгон урвал, хүндрэлийг судлан мэдээний хамт энэ оны 10 дугаар сарын 20-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлэхийг тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгав.

Нэн шаардлагатай эмийн хангамжийн мэдээ. 2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар эм хангамжийн салбарт зонхилох байр суурь эзэлдэг Монголэмимпекс ХХК, Монофармтрейд ХХК, Еврофарм ХХК, Азифарм ХХК-аас ирүүлсэн зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдлийн мэдээгээр хот, хөдөөд 165 нэрийн нийт 2,5 тэрбум төгрөгийн үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлтэй байна.

Энэ сард ЭМЯ-ны импортын зөвшөөрлийн дагуу 48 эм ханган нийлүүлэх байгууллага гэрээний дагуу импортын лицензэд заагдсан 470 нэрийн эм, 160 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 92 нэрийн урвалж бодис оношлуур тус тус импортоллоо.

Цочмог халдварт өвчний өвчлөл, нас баралт, эх, хүүхдийн эндэгдлийн мэдээ, үнэлгээ. 2008 оны эхний 8 сард улсын хэмжээнд нийт 41521 эх амаржиж 41638 амьд хүүхэд төрж өнгөрсөн оныхоос төрсөн эх 6536-аар, амьд төрсөн хүүхдийн тоо 6598-аар тус тус нэмэгдсэн байна. Энэ хугацаанд 17 эх эндэсний 7 нь Улаанбаатар хотод, аймгуудаас Баян-Өлгийд 2, Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд, Хэнтий аймагт тус бүр 1 эх эндэсэн байна. Эхийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 100000 амьд төрөлтөнд 34,8-аар буурсан байна (100000 амьд төрөлтөнд 40,8 байна).

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 833 тохиолдол бүртгэгдэж өмнөх оныхоос 208-аар, 1000 амьд төрөлтөнд 1,7 пунктээр тус тус нэмэгдсэн, Өвөрхангай 68(37,4), Дорноговь 28(33.3), Говь-Алтай 30(32.4), Архангай 40(29,8), Хэнтий 27(27.9), Баянхонгор 37(27.5), Хөвсгөл 56(27.0), Говьсүмбэр 5(25.6), аймагт улсын дундаж /20,0/-аас өндөр байна.

1-5 хүртэлх насны 168 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 11-ээр, амьд төрсөн 1000 хүүхдэд 24,0 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.2 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2008 оны эхний 8 сард 28565 халдварт өвчин бүртгэгдсэн нь урьд оны мөн үеийнхээс 1131 тохиолдлоор нэмэгдэж 10000 хүн амд 107,5 ногдож байна.

Бүртгэгдсэн халдварт өвчний дотор вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, гонококкт халдвар, хүнснээс гаралтай бактерт хордлого зэрэг өвчний тохиолдлын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс нэмэгдсэн байна.

Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 35,9%, гэдэсний халдварт өвчнүүдээс вируст гепатит 22,4%, амьсгалын замын халдварт өвчнөөс сүрьеэ 11,0%, салхин цэцэг 6,0%, гахай хавдар 1.6%-ийг тус тус эзэлж байна. Өргөн дархлаажуулалт

бүхий халдварт өвчнүүдээс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад зэрэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Халдварт өвчний улмаас 109 хүн нас барснаас сүрьеэгээр 63, вируст гепатитээр 21, менингококкт халдвараар 9, төрөлхийн тэмбүүгээр 3, салхин цэцэг, нярайн цусан үжил, хачигт энцефалит, цусан суулгаар тус бүр 2, хүнсний гаралтай бактерт хордлого, ёлом, хийт үжжил, ХДХВ-ийн улмаас тус бүр нэг хүн нас барсан байна.

### **Санхүү, эдийн засгийн чиглэлээр:**

Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах Зөвлөлийн мэдээллийг Сангийн сайд Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өмнөх сарынхаас буурсан буюу харьцангуй тогтвортой, махны үнэ үхрийн цул махнаас бусад нь 2.0-3.7 хувиар буурсан, “Алтан тариа” ХК-ийн дээдийн дээд гурилын үнэ ялимгүй өсөж, бусад гурилын үнэ тогтвортой үнээр хадгалагдаж байна. Бензин, шатахууны үнэ наймдугаар сард 2 удаа нэмэгдсэн явдал үнэ тогтвортой буурахад сөрөг нөлөө үзүүлжээ.

Дипломат төлөөлөгчийн газруудын 2006 оны сүүлийн хагас жил, 2007 оны болон 2008 оны эхний хагас жилийн санхүү, бүртгэл, тайлангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн тухай Сангийн сайд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлээр санхүүгийн сахилга батыг чанд сахиж, төсвийг үр ашигтай захиран зарцуулж байхыг Гадаад хэргийн яам, холбогдох Элчин сайдын яам, консулын газруудад үүрэг болгосон байна.

Цалин тогтоох нэгжийг шинэчлэн батлах тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын цалин тогтоох нэгжийг шинэчлэн баталсан байна.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн ноот бичгийн төслийг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн ноот бичгийг солилцох нь зүйтэй гэж үзсэн байна.

Импортын автобензин, дизелийн түлшинд ногдох татварын тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 22-ний өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, импортын автобензин, дизелийн түлшинд ногдох импортын татварыг 2008 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ногдуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ 2008 оны үлдэж буй хугацаанд нефть бүтээгдэхүүний татварын орлогоор 72.0 орчим тэрбум төгрөг (үүнээс: гаалийн албан татвараар 15.7 тэрбум төгрөг, онцгой албан татвараар 18.4 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 38.0 тэрбум төгрөг) төвлөрүүлэхээр тооцсон байна. Өөрөөр хэлбэл, 2008 онд нефть бүтээгдэхүүний татварын орлогоор 183 орчим тэрбум төгрөг оруулахаар төлөвлөж байснаас 139.0 тэрбум төгрөг төвлөрч 43.0 гаруй тэрбум төгрөгөөр орлого буурахаар байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 2008 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн) хуралдаанаар танилцсан байна. УИХ-аас “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан”-д 2008 онд 30.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар хуваарилан баталсан байна. УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэрээс 15.0 тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчдэд, үлдэх 15.0 тэрбум төгрөгийг зам тээвэр, аялал жуулчлал, үйлдвэр, худалдаа, эрчим хүчний салбарын үйлдвэрлэгчдэд зориулан 5-аас доошгүй жилийн хугацаатай, жилийн 15-аас дээшгүй хувийн хүүтэй зээлийг арилжааны банкаас олгосон нөхцөлд хүүгийн 50 хувийн төлбөрийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас төр хариуцан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүний дагуу 2008 оны эхний хагас жилийн байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яамнаас сонгон шалгаруулж ирүүлсэн 127 аж ахуйн нэгж, иргэдийн боловсруулсан төсөлд арилжааны банкуудаас олгосон 65.96 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн төлбөрийн хөнгөлөлтийн урамшуулалд зориулан Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас нийтдээ 18.23 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын даргад 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн барилаа. Үндсэн чиглэлийн төсөлд инфляцийн хэт өсөлтийг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах замаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, нягтлан бодох бүртгэл, аудитын болон хөрөнгийн үнэлгээг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг эрчимжүүлэх, хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг дэмжсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, улмаар байгаль экологид ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарт шинэчлэл хийж, найдвартай ажиллагааг хангах, түүнчлэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах зэрэг 6 бүлэг бүхий 202 зорилт, арга хэмжээг тусгасан байна.



МАХН, АН-ын хамтарсан Засгийн газрын анхдугаар хуралдааныг (2008 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр) зохион байгуулж, “Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган тодотгон боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд, Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон байна. Үүнтэй уялдуулан “Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусгах замаар хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Үүний дагуу “Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг дагалдах хуулиудын хамт УИХ-ын даргад (2008 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр) өргөн барилаа.

“Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсанаар ДНБ-нд эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгах, улсын төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, улмаар үнийн өсөлтийг саармагжуулах, хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, төсвийн орлогын төлөвлөгөөг илүү бодитой болгоход илүүтэй анхаарч ажиллах нь зүйтэй гэж Засгийн газар үзсэн байна. Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар улсын төсвийн алдагдал 15.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэх юм. Харин Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлогыг 100.3 тэрбум төгрөгөөр, түүний эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг 10.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тооцсон байна.

“Монгол Улсын 2009 оны төсвийн тухай” хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусгах замаар төсвийн төслийг дахин тодотгохоор болсон байна. Улмаар Монгол Улсын 2009 оны төсвийн төслийн тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцэж, төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна. Үүний дагуу “Монгол Улсын 2009 оны төсвийн тухай” хуулийн төслийг УИХ-ын даргад 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн барьсан байна. Ирэх 2009 оны төсвийн төслийг боловсруулах явцад УИХ-аас зөвшөөрсөн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл”-ээр тогтоосон эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон төсвийн тэнцвэрийн макро үзүүлэлтийг хангах, 2008 оны эхний 8 сарын эдийн засаг, төсөв, санхүүгийн байдал, 2008 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан цаашдын хандлагыг тодорхойлж, улмаар Засгийн газрын зарлагыг хязгаарлах, цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх, төрийн албаны ажилтны орон тоо, зардлын хэмжээг өсгөхгүй байх, амин чухал бус хөрөнгө оруулалт болон тэвчиж болох урсгал зардлыг багасгах зэрэг нөхцөл, шаардлагыг төсөлд харгалзан үзсэн байна. Засгийн газар ирэх 2009 оны төсвийн жилээс эхлэн цалин, тэтгэвэр нэмэгдүүлэх шийдвэрийг урьдчилан зарладаг явдлыг зогсоож, гагцхүү ерөнхий төлөвлөлтийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч нартай тохиролцсоны дагуу цалин хөлсийг улирлын хуваарьтайгаар нэмэгдүүлдэг журамд шилжих нь зүйтэй гэж үзсэн байна.

Сангийн сайд Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2009 оны төсвийн зарлагын төсөөллийг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд урьдчилан танилцуулсан байна. Засгийн газрын хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарлагын хязгаарыг нягтлан хянаж, улмаар Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2009 оны төсвийн зарлагын хязгаарыг батлуулах тухай тогтоолын төслийг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргахаар тогтсон байна.

Монгол банкны боловсруулсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг зарчмын хувьд дэмжиж, үндсэн чиглэлийн төслийн 1.1-ийг “Дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, хүнсний хангамж зэрэг нийлүүлэлтийн шалтгаанаар өдөөгдсөн инфляцийг шат дараатай бууруулах арга хэмжээ авна. Төрөөс мөнгөний бодлогын гол зорилт нь 2009-2011 онд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг дунджаар 9.5 хүртэл хувьтай байлгахад оршино.” гэж, үндсэн чиглэлийн төслийн 1.3-ыг “Төгрөгийн ханш нь валютын захын эрэлт, нийлүүлэлт болон инфляцтай уялдаж байх зарчмыг баримтална.” гэж өөрчлөн найруулахын хамт үндсэн чиглэлийн төслийн 2 дугаар бүлэгт “Олон улсын санхүүгийн зах зээлээс хямд, урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллана.” гэсэн заалтыг нэмж тусгах саналыг уламжлахаар тогтсон байна. Үүнтэй уялдуулан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлийн тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцэж, дэлхий дахинд үүсээд байгаа санхүүгийн хямрал манай улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар судалгаа хийж санал боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Боловсролын салбарын шинэчлэлийн төсөл”-ийн буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн тухай Засгийн газрын (2008

оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Сангийн сайд С.Баярцогтод хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрх олгохоор шийдвэрлэлээ.

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх зарим авах арга хэмжээний тухай Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн) хуралдаанаар дахин хэлэлцсэн байна. Засгийн газрын хуралдаанаас “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулж, эдгээр хуулийн төслийг боловсруулж Засгийн газарт оруулах, улмаар шингэн түлшний үйлдвэр байгуулах, “Дөчин мянган орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтворжуулах талаар санал боловсруулан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах, түүнчлэн төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судлан санал оруулахыг холбогдох сайд нарт нь үүрэг болгосон байна.

Сангийн сайд, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын (2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 3169/135 дугаар) хамтарсан тушаалаар Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын 2008 оны шинэчилсэн төлөвлөгөөг баталж, улсын чанартай авто замын арчлалт, урсгал засварын 52 төрлийн ажилд 5535.6 сая төгрөг, зам, гүүрийн их засвар, шинэчлэлт, зураг төсөл, үйлдвэрлэлийн баазын бэхжилтийн зэрэг 7 төрлийн ажилд 3312.1 сая төгрөг, авто замын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зардалд 166.8 сая төгрөг, нийтдээ 9014.5 сая төгрөгийг зарцуулахыг зөвшөөрсөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн шугамаар шинээр байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг яамдаас ирүүлсэн санал болон УИХ-ын ээлжит сонгуульд ялалт байгуулан УИХ-д суудалтай болсон намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, МАХН, АН-ын хамтран ажиллах гэрээ, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичгийн зорилттой уялдуулан 9 бүлэгтэйгээр боловсруулсан байна. Энэхүү баримт бичгийн төслийг Сангийн сайдад танилцуулж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.

Монгол Улсын 2008 оны төсвийн тодотголын төслийн танилцуулга, үндсэн үзүүлэлтийг нэгтгэн боловсруулж гаргасан байна. Монгол Улсын 2008 оны төсвийн тодотголыг батлуулснаар улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2,481.2 тэрбум төгрөгт, нийт зарлага 2,510.9 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 29.7 тэрбум төгрөгийн буюу ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай, улсын төсвийн орлого 1,704.7 тэрбум төгрөг, зарлага 1,810.9 тэрбум төгрөг болсноор улсын төсвийн нийт тэнцэл 106.2 тэрбум төгрөгийн буюу ДНБ-ий 1.8 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар бодож, энэхүү алдагдлыг гадаад зээлийн ашиглалтын эх үүсвэрээр нөхөхөөр тооцсон байна. Монгол Улсын 2008 оны төсвийн тодотголын төслөөр төсвийн нийт орлого 54.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн нийт зарлага 53.9 тэрбум төгрөгөөр буурч, үүний дүнд төсвийн нийт тэнцэл 107.9 тэрбум төгрөгөөр сайжирсан байна.

“Монгол Улсын 2009 оны төсвийн тухай” хуулийн төслийн танилцуулга, тооцоог гаргасан байна. Төсвийн орлогын 2009 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах явцад төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн мөрдөж буй хууль эрхзүйн орчин, Засгийн газраас эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн өсөлт, эдийн засгийн гадаад ба дотоод орчны нөлөөлөл зэргийг бодолцож, Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг Төсвийн хүрээний мэдэгдлээс 190.0 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нийт орлогыг 2.6 триллион төгрөгт хүргэхээр тооцсон байна.

Төв, орон нутгийн төсвийн байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн өртөг зардалд судалгаа явуулж, ирэх 2009 оноос хөтөлбөрт суурилсан төсвийн төсөвлөлтөд шилжүүлэхтэй уялдуулан олон жил хэрэгжүүлсэн хэдий ч үр дүн багатай ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх, нэн тэргүүнд шаардлагатай арга хэмжээ, бүтээгдэхүүн нэг бүрийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан төсвийн зарлагын төслийг боловсрууллаа. Ингэснээр 2008 оныхоос урсгал засвар, дотоод ба гадаад албан томилолтыг 50 хувиар, шинээр нэмэгдэж буй ажлын байрнаас бусад байгууллагын эд хогшлын зардлыг зуун хувиар бууруулах бодлого барьж ажилласан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний найман сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, мэдээлсэн байна. **Үүнд:**

(1) Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2008 оны эхний найман сарын гүйцэтгэлээр **1,405.1** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 18.7 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар давуулан биелүүлж, 2007 оны мөн үеийнхээс 33.6 хувиар буюу 353.2 тэрбум төгрөгөөр илүү байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалж үзвэл татварын орлогоор 87.8 хувийг, татварын бус орлогоор 11.9 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.3 хувийг бүрдүүлсэн байна.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2008 оны эхний найман сарын төлөвлөгөөгөөр 1,848.8 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1,362.3 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр **1,401.4** тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 1,073.8 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 75.8 хувийг (улсын төсвийн зарлагын 78.8 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2007 оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 560.8 тэрбум төгрөгөөр буюу 66.7 хувиар (улсын төсвийн зарлага 2007 оны мөн үеийнхээс 271.5 тэрбум төгрөгөөр буюу 33.8 хувиар) өссөн байна. Нийт

урсгал зардлын 13.8 хувийг буюу 149.7 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардал, 33.9 хувийг буюу 369.1 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, *өөрөөр хэлбэл*, нийт зардлын 47.7 хувийг буюу 518.8 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардалд зарцуулсан байна.

(3) Орон нутаг 2008 оны эхний наймдугаар сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 6.7 хувиар буюу 8.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, төсвийн зарлагын 95.1 хувийг буюу 6.4 тэрбум төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 34.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 32.9 тэрбум төгрөгийг оруулсан бөгөөд харин Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь аймгууд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна.

(4) Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны эхний найман сард зарим бараа бүтээгдэхүүний албан татвараар **289.3** тэрбум төгрөг төвлөрүүлж, сангийн оны эхний үлдэгдлээс 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 66.0 тэрбум төгрөг; Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 58.0 тэрбум төгрөг (нийт **123.9** тэрбум төгрөг)-ийг зарцуулсан байна.

(5) Монгол Улсын нэгдсэн төсвийн (*өссөн дүнгээр*) 2008 оны эхний найман сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл **312.5** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **3.7** тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 17.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 178.0 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна. Улсын төсвийн алдагдал сар тутам өсөн нэмэгдэж байгаагаас улсын төсвийн орлого төлөвлөгдсөн хэмжээнд бүрдэж чадаагүйтэй шууд холбоотой байна.

Улсын төсөвт байгууллагын 2008 оны эхний найман сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2008 оны эхний найман сарын өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний найман сарын гүйцэтгэлээр (2008 оны ёсдүгээр сарын 1-ний үлдэгдэл) төсөвт байгууллагуудын төсвийн нийт авлага **5,909.4** сая төгрөгт хүрч, 2008 оны эхнээс 1,488.6 сая төгрөгөөр, төсвийн нийт өглөг **6,046.3** сая төгрөгт хүрч, 2008 оны эхнээс 830.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Төсвийн байгууллагын өр оны эхнээс нэмэгдэхэд зах зээл дэх хэрэглээний барааны үнэ өссөн явдал голлон нөлөөлсөн байна.

Төсвийн төлөвлөгөөнд жилийн туршид инфляцийн дунджийг 6 хувь байхаар тооцсон хэдий ч инфляцийн түвшин 2008 оны эхний найман сарын байдлаар өмнөх оны мөн үеэс **34.0** орчим хувиар өссөн дүнтэй гарсан байна. Нийт авлагын 94.5 хувийг буюу 5,712.8 сая төгрөгийг, нийт өглөгийн 86.6 хувийг буюу 5,114.8 сая төгрөгийг улсын төсөвтэй харьцдаг төсвийн байгууллагууд үүсгэснээс улсын төсөвтэй харьцдаг төвийн байгууллагуудын авлага 4,988.9 сая төгрөгт, өглөг 2,604.3 сая төгрөгт, орон нутгийн байгууллагуудын авлага 724.0 сая төгрөгт, өглөг 2,510.5 сая төгрөгт хүрсэн байна.

Улсын төсөвт төв, орон нутгийн байгууллагын 2008 оны гуравдугаар улирлын төсвийн хуваарийг Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд зөөвөрлөн оруулж, төсвийн зарцуулалтын эрхийн баталгаа болон төвлөрүүлэн захирагч нарын зарцуулалтын эрхийн дэд баталгааг хянаж, түүнийг нэгдсэн сүлжээнд суулган төсөвт байгууллагын зардлын төлбөр тооцоо гүйцэтгэх, урсгал зардалд хяналт тавих бололцоог хангасан байна. Зарим байгууллагын төсвийн зарлагын хуваарьт 2008 оны есдүгээр сард өөрчлөлт орсонтой холбогдуулан санхүүжилтийн тооцоог дахин хийж, нэгдсэн сүлжээнд хуваарийн дагуу татаж оруулах арга хэмжээ авлаа.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2008 оны гуравдугаар улирлын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, 2008 оны есдүгээр сарын урсгал зардалд **26.4** тэрбум төгрөг нэмж гаргах замаар 2008 оны эхний өсөн сарын байдлаар (*өссөн дүнгээр*) **879.0** тэрбум төгрөгийн санхүүжилт олгох арга хэмжээ авлаа.

Монгол Улсыг хөгжүүлэх сан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, Засгийн газрын нөөц сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнаж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2008 оны эхний найман сарын байдлаар Засгийн газрын нөөц сангаас **12.7** тэрбум төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийн хэмжээ дууссанаас Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр Засгийн газрын шийдвэрлэсэн 2,770.0 сая төгрөгийн санхүүжилт одоогоор хүлээгдэж байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас хүнс, хөдөө аж ахуйн ба үйлдвэрлэлийн зээлийн хүүгийн урамшуулалд 2008 оны эхний өсөн сард 17.7 тэрбум төгрөгийг хувь хүн ба аж ахуйн нэгж, байгууллагад олгосон байна. Засгийн газрын тогтоол, Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын хамтарсан тушаалын дагуу түлш, шатахууны үнийн өсөлтийн зөрүүд Эрсдлийн сангаас 3,504.4 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн явц хангалтгүй дүнтэй байгаа тухай болон Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэр гарсан шийдвэрийг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй болсон тухай дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж, түүнийг Сангийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулсан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тусгай дансанд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 2008 оны эхний өсөн сарын байдлаар **335.1** тэрбум төгрөгийг төвлөрүүлж, **179.6** тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны 10 дугаар сарын 1-ний үлдэгдэл **452.5** тэрбум төгрөг болсон байна: Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай

хуулийн дагуу хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 71.5 тэрбум төгрөг (тухайн сард 13.5 тэрбум төгрөг); (2) 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид зориулан 66.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний батлагдсан хуваарь, түүний өөрчлөлтийг программ хангамжид байрлуулж, төсвийн санхүүжилт олгох боломжийг бүрдүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 оны эхний есөн сарын байдлаар нийтдээ **156.3** тэрбум төгрөг (тухайн сард 23.6 тэрбум төгрөг)-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Батлагдсан хуваарийн дагуу орон нутгийн төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд 2008 оны эхний есөн сард улсын төсвөөс 46,959.9 сая төгрөг (хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 30,586.6 сая төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 2,675.0 сая төгрөг, их засварын зардалд 13,698.3 сая төгрөг)-ийн, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 13,446.7 сая төгрөгийн нийтдээ **60,406.6** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хуваарилан олгосон байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв нь 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн улсын төсөв, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн төсөв гэсэн дөрвөн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн гаргадаг боллоо. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны долоодугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, дүнг яамны удирдлага болон Үндэсний статистикийн газар, Монголбанк, ОУВС зэрэг нийт 13 газарт хүргүүлж мэдээлсэн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2007 оны дөрөвдүгээр сарын гүйцэтгэл, тайлангийн үндсэн үзүүлэлтийг Сангийн яамны вэб хуудсанд байрлуулан олон нийтэд нээлттэй, ил тод танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын төсвийн ба нэгдсэн төсвийн 2008 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн боловсруулж гаргалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний хагас жилийн тайлангаар улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 191.9 тэрбум төгрөгийн, урсгал тэнцэл 53.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 4.9 хувьтай тэнцэж байна. Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл алдагдалтай гарсан нь улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасарсантай шууд холбоотой байна. Нийгэмд үүссэн эдийн засгийн бодит байдалд дүгнэлт хийж, Засгийн газрын шийдвэрээр зарим нэр төрлийн бараа, бензин, дизелийн түлшний гаалийн ба нэмэгдсэн өртгийн албан татварыг тодорхой хугацаагаар чөлөөлсөн явдал 2008 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт орлогын гүйцэтгэлд шууд нөлөөлсөн байна.

Монгол Улсын үйлчилгээний тэнцлийн 2009-2012 оны төсөөллийг түүний төрөл тус бүрээр боловсруулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн баримт бичгийн төлбөрийн тэнцлийн хэсэгт тусгасан байна. Төлбөрийн тэнцлийн төлөв, хандлагын тухай агуулгыг дурдвал: төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэл 2008 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр албан шилжүүлгийг оролцуулан 489.7 сая ам.долларын алдагдалтай байгаа бол 2009 онд 427.6 сая ам.долларын алдагдалтай буюу 62.1 сая ам.доллараар нэмэгдэх төлөвтэй байна. Төлбөрийн тэнцлийн урсгал дансны ашиг 2008 онд албан шилжүүлгийг оролцуулан ДНБ-ий -9.8 хувь байгаа бол 2009 онд ДНБ-ий -7,3 хувьтай тэнцэхээр байна. Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал үлэмж нэмэгдэж байгаа нь хүнсний болон нефтийн бүтээгдэхүүний үнэ олон улсын зах зээлд ихээхэн хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Түүнчлэн 2008 оны эхний 8 сарын байдлаар экспортолсон алт, зэсийн баяжмал болон импортолсон нефтийн бүтээгдэхүүний биет хэмжээ, өртөг, үнийг өмнөх онтой харьцуулсан судалгаанаас үзэхэд 2008 оны эхний 8 сард алт, зэсийн үнийн өсөлтөөс олсон экспортын орлого 302.0 сая ам. доллар буюу 349.4 тэрбум төгрөг болсон байна. Нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс 200.3 ам. доллар буюу 231.7 тэрбум төгрөгийн зарлага гарах байсан боловч 77.2 мянган тонн нефтийн бүтээгдэхүүн илүү импортолсны улмаас 173.0 мянган ам. доллар буюу 200.1 тэрбум төгрөгийн зарлага нэмж гарсан байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, 2008 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийтдээ Сангийн яамны Төрийн сангийн газар, нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 203 сумын 610 хэрэглэгч Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдон өдөр тутмын төсвийн санхүүжилт, төлбөр тооцооны ажлыг гүйцэтгэж байна. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээний хэрэглэгчдийн техникийн болон функционал гарын авлагыг бэлтгэж, хэвлүүлэх арга хэмжээ авлаа. Мөн Үндэсний татварын ерөнхий газраас 22898 аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаарыг хүлээн авах замаар мэдээллийн баазыг бэлтгэж, түүнийг Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд импортлон оруулснаар аж ахуйн нэгж, байгууллагуудын чирэгдлийг багасгаж чадсан байна.

“Атрын гурав дахь аян”- тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн ашиглалтыг шалгах тухай” Сангийн сайдын 2008 оны 295 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Төв, Завхан, Увс, Хөвсгөл аймагт ажиллаж, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдсон зээлийн ашиглалт, хэрэгжилтийн байдлыг газар дээр нь биечлэн танилцсан шалгалтын ажлын дүнг Засгийн газрын (2008 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн) хуралдаанд танилцууллаа. Засгийн газрын дотоод зээл болох улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр шинээр олгосон зээлийн хэмжээ 2008 оны эхнээс 9 дүгээр сарын байдлаар **39.99** тэрбум төгрөг, мөн урьд онуудад олгосон зээлийн эргэн төлөлт **125.97** сая төгрөг болсон байна.

Азийн хөгжлийн банкны шугамаар ирж ажилласан зөвлөх нартай хамтран “Нийгмийн эмзэг бүлгийн зарим хэсэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг яамдаас ирүүлсэн санал зэргийг тусгах замаар тодотгон боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 30 орчим тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр шаардлагатай бөгөөд үүний 10 орчим тэрбум төгрөгийг Азийн хөгжлийн банк гаргахаар болсон байна. Эл хөрөнгийн үлдэж буй эх үүсвэрийг Монгол Улсын төсвийн хөрөнгөөс болон гадаад эх үүсвэрээс гаргахаар тооцсон байна.

Монгол-Европын холбооны хоорондын Хамтарсан хорооны хуралдааныг (2008 оны 9 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд) зохион байгууллаа. Энэ үеэр Монгол-Европын холбооны Худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын дэд хорооны хуралдааныг зохион байгуулж, уул уурхайн салбарын өнөөгийн хөгжил болон хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаа, Монголын зах зээлийн эдийн засгийн статус болон Европын холбооны худалдааны ерөнхий хөнгөлөлтийн "GSP+" журмын ашиглалт, Европын хөрөнгө оруулалтын банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хэрэгжүүлэх хамтын ажиллагааны тухай ярилцаж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн бусад асуудлыг хэлэлцсэн байна. Хамтарсан хорооны хуралдааны хүрээнд Монголын тал Европын холбооны Ерөнхий хөнгөлөлтийн "GSP+" журамд хамрагдах хугацаагаа сунгуулах хүсэлтээ албан ёсоор тавихаа мэдэгдсэн байна.

Азийн хөгжлийн банкны 12 сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлэх “Эмзэг бүлгийн иргэдэд хүнсний тусламж үзүүлэх” төслийн бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг Улаанбаатар хотноо (2008 оны 9-р сарын 8-12-ны өдрүүдэд) ирж ажиллалаа. Ажлын хэсэгтэй уулзалт зохиож, энэхүү төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцож, зохих тохиролцоонд хүрсэн байна. Энэхүү төсөл нь “Засгийн газрын Нийгмийн эмзэг бүлгийн зарим хэсэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-т дэмжлэг үзүүлэх юм. Засгийн газрын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуульд тусгасан 1.5 тэрбум төгрөг батлагдсан тохиолдолд 2008 оны 11 дүгээр сараас эхлэн туршилтын хоёр аймаг, нийслэлийн дүүргүүдийн тэтгэврийн насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шинэчилсэн нэрсийн жагсаалтаар хүнсний тасалбарыг олгож эхлэх юм.

Азийн хөгжлийн банк Нийгмийн эмзэг бүлгийн зарим хэсэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрт 2009 оны эхнээс дэмжлэг үзүүлэх ажээ. “Эмзэг бүлгийн иргэдэд хүнсний тусламж үзүүлэх” төслийн Харилцан ойлголцлын санамж бичигт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн мэргэжилтэн (К.Бодарт) нар (2008 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр) гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Итали Улсын Засгийн газраас Монгол Улсад тохиолдсон зудын гамшгийг даван туулахад зориулан нийт 500,000 еврогийн үнэ бүхий тахианы нөөшилсөн махыг хүнсний тусламж болгон олгох тухай Солилцох захидалд Сангийн сайд (2008 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр) гарын үсэг зурж баталгаажуулав.

#### **Үйлдвэр, худалдааны салбарт:**

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Монгол Улсад чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх үзэл баримтлалыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барив.

“Худалдааны хамгаалалтын арга хэмжээний тухай” хуулийн төслийг боловсруулж байгаатай холбогдуулан “Худалдааны хамгаалалтын арга хэрэгслүүд” сэдэвт үндэсний семинарыг зохион байгуулав.

Монгол-Европын Холбооны ЗГХК, Худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын дэд хорооны 10 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг цаашид өргөжүүлэх талаар санал солилцов.

Монгол Улс Европын Холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдах хугацааг 2009-2011 онд сунгах өргөдөл гаргахтай холбогдуулж, 27 конвенцийн хэрэгжилтийн тайланг Европын Холбоонд хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Казакстан Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох болон үйлдвэр байгуулах талаар санал солилцон, Монгол-Казакстаны хөрөнгө оруулалтын сан байгуулахаар тохиролцов.

АНУ-ын Худалдааны яамны Олон Улсын Худалдааны албаны дэд сайдын орлогчийн албан ёсны айлчлалыг зохион байгуулж, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцож, холбогдох уулзалтуудыг зохион байгуулав.

Монгол Улсын Азербайджан, Тажикстан Улсуудтай байгуулах Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан талуудад хүргүүлэв.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн тайлан мэдээг 1991-2008 онуудаар нэгтгэн гаргаж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр 2008 оноос хэрэгжүүлж эхлэх геологийн зураглал, судалгааны ажил гүйцэтгэх тендерийг зохион байгуулж, 5 багцад гэрээ байгуулах эрх олгох тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг АМГТХЭГ-т хүргүүлж, 5 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулав.

Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах 11 гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, гаргасан шийдвэрийн дагуу энэ 11 компанийн гэрээг шинэчлэн байгуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар хүргүүлэв.

Уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын хамтран хийсэн шалгалтын дүнг Байгаль орчны болон Үйлдвэр худалдааны сайдын хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын тухай” танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд холбогдох яамдаас санал авч, ЗГХЭГ-т хүргүүлэв.

Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэнд олгох гэрчилгээний загвар”-ыг Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар батлуулав.

ЖДҮ-ийг дэмжих Баянзүрх болон Сонгинохайрхан төвүүдийн байранд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын хэсгүүд байгуулагдан төвүүд дээр ажиллав. Засварын ажлыг гүйцэтгэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн материалыг үнэлж, дүгнэлт гаргав.

Технологи дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах тендерийн үнэлгээний дүнг Сангийн яаманд хүргүүлж, холбогдох зөвшөөрлийг авч гэрээг байгуулав. Мөн технологи дамжуулах төвийн барилга худалдан авсан тухай мэдээлэл бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар хүргүүлэв.

Салбарын үйлдвэрүүд (Арьс шир үйлдвэрлэгчдийн холбоо, Дархан нэхий ХХК, Ноос, ноолуурын холбоо)-ийн хүсэлтийн дагуу Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолын дагуу салбарын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, холбогдох мэдээллийг бэлтгэж, ЗГХЭГ-т хүргүүлэв.

#### **Байгаль орчны салбарт:**

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчид, үнэлгээний мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлж, тэдгээрийн саналыг тусгав.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчны сайдын 252/316 тоот хамтарсан тушаалаар Ойгоос хууль бусаар мод бэлтгэх, худалдаалах, түүнтэй холбогдон үүсч болох авилгалыг таслан зогсоох ажлын хэсгийг байгуулав.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг 85 төсөлд гаргаж, нарийвчилсан үнэлгээний 53 тайланг батлав. Химийн бодисын тусгай зөвшөөрлийг 31 аж ахуйн нэгжид, ургамлын тусгай зөвшөөрөл 9 аж ахуйн нэгжид олгов. Уул уурхайн 1 аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хянан батлуулж, 18.73 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний барьцаа болгон тусгай дансанд төвлөрүүлэв.

Туул голын ай савд байрлан үйл ажиллагаа явуулж буй элс, хайрганы орд газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж хууль бус үйл ажиллагаа явуулсан 15 аж ахуйн нэгж байгууллагын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулах арга хэмжээ авсан байна.

Ой усны хайгуул судалгааны төвөөс Архангай аймгийн 18 сум, Өвөрхангай аймгийн 8 сумын ой бүхий 1220.9 мянган га талбайд хээрийн судалгааны ажлыг явуулж, нийслэлийн ногоон бүсийн ой зохион байгуулалтын зураглалын ажлыг хийж дуусгаад байгаагийн зэрэгцээ Баян-Өлгий аймгийн ой бүхий 10 сумын 43100 гаруй га талбайд ойн нөөцийн хээрийн хайгуул судалгааны ажлыг хийж байна.

Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ аймгуудад ойн хөнөөлт шавьж, өвчний судалгааг, Нийслэлийн ногоон бүс, Төв аймгийн ойн хөнөөлт шавьж бүхий газруудад өрөөсгөл хүр эрвээхэйн өндөг устгах ажлыг явуулж байна.

“Барилгын хэв хашмалын түр тулаасанд залуу зулзаган мод хэрэглэхийг хориглох тухай” Байгаль орчин, Барилга хот байгуулалт, Мэргэжлийн хяналт эрхэлсэн сайдуудын 214/118/19 тоот хамтарсан тушаалын хэрэгжилтийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран 24 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан шалгахад 9 нь тусгай зориулалтын материал буюу төмөр тулаас ашигласан, 8 нь модон тулаас ашигласан, 7 нь холимог тулаастай байв. Модон тулаас ашиглаж байгаа 11 аж ахуйн нэгжид мэдэгдэл өглөө.

Баянзүрх дүүргийн XI хорооны нутаг дэвсгэрт барих “Шинэ Монгол” орон сууцны хороололд хөрсний усны түвшин доошлуулах ажлын зураг төсөл, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дахь

Өлзийт Тээл голын голдирлыг нөхөн сэргээх төсөл, Баруун Нарангийн уурхайн усан хангамжийн системийн техникийн урьдчилсан төсөл, “Усны нөөцийг олон зориулалтаар ашиглах цогцолборын “Орхон-Говь” төсөл”, “Яармаг-Баянзүрхийн транзит замын дагуу Туул голын голдирлыг зарим хэсэгт шилжүүлэх техникийн зураг төсөл зэрэг томоохон төслүүдийг хянан үзэж, мэргэжлийн дүгнэлтүүдийг гаргав.

Тарвага агнахыг хориглох шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчны дэд сайдын албан даалгавар гаргав. Судалгаагаар Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурван загал, Булган сумдын зарим газарт тарвага өссөн мэдээтэй байна.

Зарим аймгийн нутагт сүүлийн өдрүүдэд тодорхой бус шалтгаанаар мал, зэрлэг амьтад, нүүдлийн шувууд олон тоогоор хорогдсон учраас Төрийн нарийн бичгийн даргын албан даалгавар гаргав. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт гарсан цагаан зээрийн цусан халдварт өвчний тархалтын хүрээг тогтоож, өвчний голомтыг устгах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулав.

Говь-Алтай аймгийн Байгаль орчны алба 7 сумын 9 нууранд 34 цэг тогтоож 21 зүйлийн 31209 гаруй шувууг хамруулан тандалт ажиглалтыг явууллаа. Тандалт ажиглалтын хугацаанд өвчний шинж тэмдэг бүхий шувуу илрээгүй, үхсэн шувуу 5 илэрч зохих журмын дагуу устгал хийсэн байна.

Архангай аймгийн Өгий нуур орчимд Кувейт улсын иргэн идлэг шонхор шувуу барьсан тухай мэдээллийн дагуу нягтлан шалгах хүсэлтийг Улсын мэргэжлийн хяналтын газарт хүргүүллээ.

Байгаль орчны яам 2008 оныг байгаль орчныг хамгаалахад Төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлэх жил болгон зарлаж энэ хүрээнд төрөлжсөн уулзалтууд, эрдэм шинжилгээ практикийн бага хурал, Эко танхимын уулзалт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж төрийн бус байгууллагуудын 60 гаруй хувийг хамруулаад байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжиж үйл ажиллагаа явуулсан төрийн бус байгууллага, орон нутгийн байгаль орчны албадаас төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын цар хүрээ 2007 онтой харьцуулахад тус тус 3 дахин нэмэгдсэн байна. Нээлттэй нийгэм хүрээлэнгээс зарласан “Байгалийн шинэчлэл” төсөлд шалгарагсдын 60 гаруй хувь нь төрийн бус байгууллагууд байсан нь өмнө нь төрийн бус байгууллагаар хэрэгжүүлж байсан төслүүдийн тооноос 2 дахин нэмэгджээ. Үүний үр дүнд 59 төрийн бус байгууллагаас 230 шахам сая төгрөгийн төслийг цөлжилттэй тэмцэх, ойжуулалт, ой хамгаалах арга хэмжээ, “Байгаль орчны шинэчлэл” төсөл, Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

2008 оны байдлаар Байгаль орчны салбарт 2753 төрийн албан хаагч ажиллаж байгаа бол тус салбарын иргэний нийгмийн байгууллагуудад хамрагдагсдын тоо тэдгээрээс даруй 3 дахин олон байна. Энэ нь байгаль хамгаалах үйл хэрэгт тэдгээрийн үр нөлөө хичнээн их өсч байгааг харуулж байна.

Байгаль орчныг хамгаалахад Төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлэх жилийн хүрээнд 11 дүгээр сард байгаль орчны төрийн бус байгууллагуудын улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулахаар шийдвэрлэж бэлтгэл ажлыг хангаж байна.

Цаг агаарын урьдчилсан мэдээ, тойм зөвлөмж. Бүх төрлийн урьдчилсан мэдээний таарц төлөвлөгөөт даалгавраас 6.0-8.6-иар ахиу, өнгөрсөн оны мөн үеэс 1.0-2.3 хувиар дээгүүр байв. Сарын урьдчилсан мэдээний таарц 66.3%, төлөвлөгөөт даалгавраас 4.3 хувь ахиу байв.

Энэ сард Урьдчилсан мэдээлэх товчоодын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан илрүүлсэн хувь 93.1 байна. 8 дугаар сард нийт 428 аюул, агаарын мэдээ ирсний дийлэнхи хувийг “хуурайшил”-ын мэдээ эзэлж байна.

2008 оны 08 сард олон улсын шугамд ниссэн 357, орон нутгийн 390, онцгой, тусгай үүргийн 31 нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн. Чингис хаан ОУНБ-ын 24 цагийн урьдчилсан мэдээ 93 удаа, 9 цагийн урьдчилсан мэдээ 248 удаа зохиосноос мэдээний таарц 86.4% байна.

Районы урьдчилсан мэдээ 175, угталтын урьдчилсан мэдээ 43, Airmet мэдээ 9, нислэгийн дагуух аюултай үзэгдлийн SIGMET урьдчилсан мэдээ 17, Улаанбаатар, Сайншанд, Мөрөнгийн районы өндрийн салхины урьдчилсан мэдээ 93, суултын урьдчилсан мэдээ 2, Аэродромын урьдчилсан мэдээ 62-ыг тус тус зохиож нислэгт үйлчилсэн байна.

Нислэгт зориулсан METAR, SPECI бодит мэдээ 1730, уур амьсгалын мэдээ 248, аюул агаар 9, CLIMAT мэдээ 1 тус тус дамжуулж, нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байна.

Тойм, зөвлөмжүүдийг интернетэд тавьж, электрон хэлбэрээр бүх аймгууд руу сүлжээгээр явуулж, холбогдох яамд болон бусад байгууллагуудад хүргүүллээ. 2008-2009 оны өвөл, хаврын бэлчээрийн даац багтаамжийг улсын хэмжээгээр багийн түвшинд тооцоолж холбогдох байгууллагуудад хүргэж, Хүйтний улирлын төлөв байдлын мэдээнд оруулан хэвлүүлж тараалаа.

2008-2009 оны хүйтний улирлын урьдчилсан төлөв, 9 дүгээр сарын цаг агаарын сарын мэдээ гарган хэвлэж төр, засгийн байгууллагууд, хэрэглэгчдэд хүргэв.

Агаарын шинжилгээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.007 мг/м<sup>3</sup> хүрч, нийт 54 удаагийн ажиглалтаар Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 0.026

мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.059 мг/м<sup>3</sup> хүрч, нийт 56 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол Баруун 4-н замын орчимд 1 удаа, 13 дугаар хорооллын орчимд 7 удаа тус тус ажиглагдсан байна.

УБ-1, УБ-2 харуулуудад агаар дахь гол бохирдуулагчид болох CO, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, PM-10 тоосонцрыг тодорхойлох автомат багаж шинээр суурилуулан хяналт-шинжилгээг хийж эхэллээ.

Агаарын сорьц авагч багажийн шалгалт, тохируулгыг хийж, орон нутгийн харуулуудад хуваарийн дагуу хүлээлгэж өглөө.

Усны шинжилгээ. Туул голын ус хотоос дээш хэсэгт бохирдолгүй цэвэр байсан ба Налайх, Баянзүрхийн орчим голын усанд нитритийн азотын агууламж Усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас бага зэрэг давсан байна. Харин Туул- Зайсангийн орчим нитритийн азотын бохирдол маш ихээр илэрч хүлцэх агууламжаас 11.3 дахин их буюу их бохирдлын түвшинд хүрсэн байлаа.

Хотоос доош буюу хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал нийлснээс доош Сонгиноос Алтанбулаг сум хүртэлх хэсэгт голын усан дахь аммонийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.6-3.0 дахин, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 7.7-17.8 дахин, эрдэс фосфорын агууламж хүлцэх агууламжаас 2.1-4.8 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч агууламж хүлцэх агууламжаас 1.1-1.4 дахин давсан бохирдол илэрчээ.

Мөн Сэлбэ гол-Улаанбаатарын орчим голын усанд нитритийн азот, хромын бохирдол маш их илэрч, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 7.3 дахин, хромын агууламж хүлцэх агууламжаас 2.3 дахин давсан байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх 4 цэвэрлэх байгууламжийн орох, гарах нийт 8 цэгээс сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд Төв цэвэрлэх байгууламж 54%, Нисэхийн цэвэрлэх байгууламж 84%, Налайхын цэвэрлэх байгууламж 84%, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 35%-ийн цэвэршилттэй байсан байна. Энэ үед Био үйлвэрийн цэвэрлэх байгууламж ажиллахгүй байлаа.

#### **Барилга, хот байгуулалтын салбарт:**

УИХ-ын 40 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын чанартай автозамын дагуух газарт өмчлүүлэх газрын байршлыг тогтоох, холбогдох зардлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан холбогдох яамдаас санал авахаар хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар баригдах Улаанбаатар хотын Буянт-Ухаагийн Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, судалгааны ажлыг гүйцэтгэх Зөвлөхийн үйлчилгээний байгууллагыг шалгаруулж KFW-д санал хүргүүлэв.

Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын алба, Европын холбооны банкны Улаанбаатар хотын “Цэвэр агаар” төслийн хууль эрх зүй, үйл ажиллагааны хүрээг тодорхойлох 1 дүгээр шатны ажлыг гүйцэтгэх багтай хамтарсан уулзалт зохион байгуулж, хэрэгжих арга хэмжээний талаар зөвшилцөв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгуудын төвд баригдах орон сууцны барилгын гадна инженерийн шугам сүлжээний болон Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд баригдах цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерүүдийг дүгнэв.

Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөл”-ийн Төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулж, Улаанбаатар хотын замын төсөл хэрэгжих байршил болон ирэх онд төсөл хэрэгжүүлэх аймгуудыг сонгон шийдвэрлэв.

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, нийтийн аж ахуйн үйлчилгээ, цахилгаан шат, өргөх кран угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилан дүгнэлт гаргах комисс”-ын 2008 оны 23 дугаар хурлын дүгнэлтийг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар “тусгай зөвшөөрөл” хүссэн 74 аж ахуйн нэгжийн материалыг судлан үзэж, барилга угсралтын чиглэлээр шинээр 22, сунгалт, нэмэлт ажилбар олгохоор 34, барилгын зураг төсөл боловсруулах чиглэлээр шинээр 2, сунгалт нэмэлт ажилбар олгохоор 3 аж ахуйн нэгжид тус тус “тусгай зөвшөөрөл” олгосон. Мөн хурлын шийдвэрийг үндэслэн барилга угсралтын болон нийтийн аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгов.

Тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг хийж, Барилга, хот байгуулалтын сайдын 138 дугаар тушаалаар 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 аж ахуйн нэгжид шинээр тусгай зөвшөөрөл олгов.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар Нийслэл хотод шинээр баригдсан 2 барилга дээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг томилон ажиллуулав.

Барилга, хот байгуулалтын сайд АНУ-ын Худалдааны яамны Олон улсын худалдааны агентлагийн Дэд сайдын орлогч Мишель О Нил тэргүүтэй албаны болон бизнесийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан АНУ-ын талтай хамтран ажиллах талаар санал солилцов.



БНТУ-д барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, Монголын барилгын салбарын ажилчид тус улсын барилгын салбарын туршлагаас судлах 2008-2009 онд хэрэгжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэв.

Барилга, хот байгуулалтын сайд UNESCAP-н Бүс нутгийн Газрын харилцаа хариуцсан удирдах албан тушаалтнуудыг хүлээн авч уулзан, тус байгууллага Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар хооронд шууд хамтын ажиллагаа тогтоон холбогдох чиглэлээр цаашид хамтран ажиллах талаар санал солилцов.

### **Түлш, эрчим хүчний салбарт:**

Түлш, эрчим хүчний сайдын 2008 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тушаалаар 25 компанид шинээр тусгай зөвшөөрөл олгож, 3 компанийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 8 компанид нэмэлт ажилбар олгов.

“Эрчим хүчний үйлдвэрлэлийн тоноглол, барилгын хийцийг зэврэлтээс хамгаалах хими хамгаалалтын ажлын технологийн заавар”, “35 кВ-оос дээш өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл боловсруулах заавар” төслүүдийг салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, IEC60227:1-IEC60227:7 цуврал 7 стандарт, “Хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний хугацаа”, “Цахилгаан эрчим хүч. Цахилгаан дамжуулах агаарын шугамын хөндийрүүлэггүй утсанд тавигдах шаардлага”, “Цахилгаан эрчим хүч. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуурын шонд тавигдах шаардлага” гэсэн 10 стандартын төслийг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Эрчим хүчний техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж ажиллав.

Түүнчлэн салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 2008-2009 оны өвлийн их ачааллын горим ажиллагаа, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Эрвэн хошууны төмрийн хүдрийн уурхайг цахилгаан хангамжийн төвлөрсөн эх үүсвэрт холбох техник, эдийн засгийн үндэслэл, 14 дүгээр хороолол, Зүүн сэлбэ хороолол, Буянт-Ухаа хорооллыг цахилгаанаар хангах техник, эдийн засгийн үндэслэл, түлш, эрчим хүчний баланс байгуулах аргачлал зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Түлш, эрчим хүчний салбарын байгууллагуудын 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хяналт тавих чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаагаас салбарын хэмжээнд өвлийн бэлтгэл хангах ажил 80 гаруй хувийн биелэлттэй байна. Холбогдох асуудлыг 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

“Дулааны цахилгаан станц-2”-ыг түшиглэн байгуулах коксон түлшний үйлдвэрийн тендерт оролцогчдыг шалгаруулж, тайлангийн материалыг Сангийн яаманд хүргүүлээд байна. Түүнчлэн брикет түлшийг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин, олон нийтийн сургалт сурталчилгаа, эдийн засаг, санхүүгийн хөшүүргийн талаар санал боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтран гүйцэтгэхээр ажиллаж байгаагаас тайлант хугацаанд гэр хороолол, түлшний жижиглэнгийн болон бөөний цэгүүд, түлш үйлдвэрлэгчидтэй уулзаж холбогдох судалгааг хийв.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх “40000 айлын орон сууцны хөтөлбөр”-ийн хүрээнд цахилгаан дамжуулах болон дулааны сүлжээг өргөтгөх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна.

2008 оны болон өнгөрсөн оны улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байгаагаас Хөвсгөл аймгийн Хатгал, Алаг-Эрдэнэ, Арбулаг сумдын төвийг төвийн эрчим хүчний системд холбох өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөний барилга угсралтын ажилд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээж авав.

Түлш, эрчим хүчний салбарт 2008 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны дагуу эхний 9 сарын байдлаар нийт 25086.4 сая төгрөгийн урьдчилгаа болон үе шатны ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэв.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар салбарт 2008 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөгөөнд тусгагдсан сумдын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэхээр Түлш, эрчим хүчний сайдын 2008 оны 116, 125, 134, 138 дугаар тушаалын дагуу нийт 123 сумдын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын гэрээ болон урьдчилгаа төлбөрийн баталгааг хянан үзэж, Сангийн яаманд хүргүүлэн нийт 3051.7 сая төгрөгийг санхүүжүүлээд байна.

Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн 2008 оны үйл ажиллагааны зардалд нийт 1,8 тэрбум төгрөг батлагдсанаас 9 сарын байдлаар 5 төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардал /Тайширын усан цахилгаан станц барих төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардалд 114.7 сая төгрөг, Дөргөний усан цахилгаан станц барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардалд 74.2 сая төгрөг, Эгийн голын усан цахилгаан станц барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардалд 5,5 сая төгрөг, Эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардалд 42.9 сая төгрөг, Эрчим хүчний хөтөлбөр-1 төсөл хэрэгжүүлэх нэгжийн

зардалд 43,2 сая төгрөг, Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардалд 40,9 сая төгрөг, Тайширын усан цахилгаан станцын зөвлөхийн зардалд 53,5 сая төгрөг, Дөргөний усан цахилгаан станцын зураг төслийг шинээр боловсруулсны зардалд 345,7 сая төгрөг/-д нийт 720.4 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлээд байна.

Түлш, эрчим хүчний салбарт гадаад орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн хүрээнд 2008 оны 9 дүгээр сарын байдлаар ажлын гүйцэтгэлийг нийт 8,9 сая ам.доллараар хянан Сангийн яаманд уламжлан санхүүжүүлэв.

#### **Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:**

“Хүнсний буудай худалдан авах” тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулав.

Хүнсний буудай худалдан авах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг Сангийн яаманд хүргүүлэв.

Засгийн газрын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын асуудлыг тусган боловсруулж байна.

“Намрын ногоон өдрүүд-2008” үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 01-07-ны хооронд “Эрүүл хүнс-2008”, “Алтан намар-2008”, “Шилмэл мал-2008” гэсэн 3 үндсэн хэсэгтэйгээр зохион байгуулж байна. Арга хэмжээнд 14 аймгийн 320 гаруй ногоочид оролцож байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Өндөр ашиг шимт сүүний чиглэлийн үхэр зээлээр олгох төсөл сонгон шалгаруулалт зарласны дагуу орон нутгаас нийт 196 иргэн, аж ахуйн нэгж төсөл ирүүлснийг сонгон шалгаруулж, яамны удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэхэд бэлэн болгоод байна.

НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Төвийн бүсийн тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд нэг ба олон наст тэжээлийн ургамлаар дарш бэлтгэх үзүүлэх сургуулийг Төв аймгийн Батсүмбэр суманд зохион байгуулав. Үзүүлэх сургуульд Төв, Сэлэнгэ, Булган аймгийн ХХААГ-ын нэвтрүүлэх төвийн ажилтнууд, 20 орчим фермер оролцов.

Ургамал хамгааллын арга хэмжээний хүрээнд 8 аймгийн 85 сумын нутагт тархсан үлийн цагаан оготно, чичүүлийн тархалт хөнөөлийн тодотгох судалгааг хийлгүүлэв. Судалгааны дүнг үндэслэн энэ оны 10-12 дугаар сард 8 аймгийн 350.0 мянган га талбайд байгаль орчинд халгүй аргаар оготной тэмцэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэж, оготной тэмцэх ажлыг гүйцэтгэх тухай гэрээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудтай байгуулаад байна.

Улсын ургацын комиссын хурлыг 2 удаа зохион байгуулж, ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай тус комиссын даргын 02 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдээс стратегийн нөөцөд 100.0 мянган тонн хүнсний улаанбуудай худалдан авах хуваарь, ХХААХҮ-ийн сайдын тушаалын төслийг боловсруулав.

Агропарк, иргэдэд бага оврын трактор олгох хуваарийг ХХААХҮ-ийн сайдын 2008 оны 175 дугаар тушаалаар батлуулав.

2009 оны шинэ худаг гаргах ажлын үндэслэл, бодлогыг төлөвлөж Сангийн яаманд хүргүүлэв. Энэ онд 7 аймагт 30 шинэ худаг гаргах ажлын 30 хувийн урьдчилгааг олгох эрх нээлгэхээр холбогдох баримтыг Сангийн яаманд хүргүүлэв.

Газрын доорхи усны геофизикийн хайгуулын ажлын дунд шатны 30 хувийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлэх ажлыг зохицуулав.

Завхан аймгийн 6 услалтын систем, Төв аймгийн 1 услалтын системийн ажилтай газар дээр нь танилцаж, санхүүжилтийн материалыг хүлээн аваад байна.

ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотод “Сибирийн муж хоорондын мал эмнэлэг” сэдэвт зөвлөлдөх уулзалтад оролцож, Монгол Улсаас ОХУ-д үржлийн болон хэрэглээний хонь, ямаа экспортлох үеийн мал эмнэлэг, хорио цээрийн шаардлага, гэрчилгээний загварыг харилцан тохиролцов. ОХУ-ын Мал эмнэлэг, ургамал хорио цээрийн албанаас Монгол Улсад шүлхий өвчний улмаас 2005 онд тогтоосон хориог цуцлах асуудал, Монгол Улсад шинээр байгуулагдсан махны үйлдвэрүүдийг итгэмжлэлд хамруулах зэрэг асуудлаар ОХУ-ын ХААЯ-ны холбогдох хүмүүстэй уулзав.

Улаанбаатар хотын орчимд үйл ажиллагаа явуулдаг шувууны аж ахуй, амьд шувуу, өндөг, тахианы мах импортлогч аж ахуйн нэгжүүд, бөөний худалдааны зах, цэг болон жижиглэн худалдааны газруудаар явж шувууны гаралтай бүтээгдэхүүний сүлжээний судалгааг хийлээ. Судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын хэмжээнд борлогдож байгаа өндөгний 32 хувийг манай шувууны аж ахуй эрхлэгчид, 68 хувийг импортоор нийлүүлдэг байна.

Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн сектор” төслийн хүрээнд бруцеллёз өвчинтэй тэмцэх талаар стартеги, уг өвчний байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллага оролцсон уулзалт, семинарыг зохион байгуулав.

НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгчийн орлогчийн газрыг Монгол Улсад нээн ажиллуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулга болон Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох яамдын саналыг нэгтгэж байна.

НҮБ-ын ХХААБ-тай хамтран “Хүнсний үнийн хөөрөгдөлд өртөгдсөн эмзэг бүлгийн хүн амд хөдөө аж ахуйн орцууд нийлүүлэх” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Хүнсний үнийн хөөрөгдлийн талаар авах арга хэмжээний хүрээнд хүнсний үнийн талаарх мэдээллийг 7 хоног бүр НҮБ-ын ХХААБ-д хүргүүлж байна.

#### **Гадаад бодлогын чиглэлээр:**

Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайдын 2008 оны 10 сард Монгол Улсад хийх айлчлалын үеэр байгуулах “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд Терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг болон бусад ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар хоорондын хамтын ажиллагааны протокол”, “Үйлдвэр, худалдааны яам, Туркийн Эрчим хүч, эрдэс баялагийн яам хооронд 2006 онд байгуулсан санамж бичиг” зэрэг баримт бичгийг байгуулахаар ажиллаж байна.

БНСУ-д амьдарч байгаа Монгол иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх салбарыг Солонгост байгуулах асуудлаар Монголын хүний эрхийн төвийн эрх зүйн мэдээллийн төвөөс хүсэлт ирүүлсний дагуу уг төвийн саналыг дэмжиж ажиллах талаар Сөүл дэх ЭСЯ-нд чиглэл өгөв.

Монгол Улс, БНАСАУ-ын Гадаад хэргийн Яамдын ээлжит зөвлөлдөх уулзалт 2008 оны 9 дүгээр сарын 16-19-нд Пхеньян хотноо болов. Зөвлөлдөх уулзалтын үеэр хоёр тал 2008-2012 онд хоёр орны харилцаанд хэрэгжүүлэх улс төр, эдийн засаг, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагаа, олон улс болон бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах асуудлаар санал солилцов. Хоёр тал Гадаад хэргийн Яамдын ээлжит зөвлөлдөх уулзалтыг 2009 онд Улаанбаатар хотноо хийхээр тохиров.

Монгол, Японы ГХЯ-д хоорондын бодлогын зөвлөлдөх уулзалтын товын талаар японы талтай санал солилцож уулзалтыг 10 дугаар сарын 7-9-нд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар тохирч бэлтгэл ажлыг эхлүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар ХБНГУ-ын Ерөнхийлөгч 9 дүгээр сарын 4-6-нд Монгол Улсад төрийн айлчлал хийв. Айлчлалын хүрээнд хоёр тал “Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагааны тухай Хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурав. “Археологийн салбарт хамтран ажиллах тухай Санамж бичиг”-т мөн гарын үсэг зурж, үүний хүрээнд манайд зориулан 330.000 евро олгох юм.

Монгол Улс Европын холбооны Хамтарсан хорооны Худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын дэд хорооны хуралдаан ҮХЯ-нд, Хамтарсан хорооны 11 дүгээр хуралдаан ГХЯ-нд тус тус амжилттай болж, хоёр тал Хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Европын холбооны Гурвалсан дарга /Тройка/ нарын айлчлалыг зохион байгуулав.

Францын Эвиан хотноо 10 дугаар сарын 6-8-ны хооронд зохион байгуулагдах “Дэлхийн бодлого” бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид оролцох үеэрээ баримтлах үндсэн чиглэл, танилцуулга зэрэг материалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна. Ерөнхийлөгч олон улсын энэ бага хурлын үеэр хоёр талын зарим уулзалтуудыг хийх бөгөөд бэлтгэл ажлыг хангаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Болгар Улсад 10 дугаар сарын 9-11-ний хооронд хийх төрийн айлчлалын үеэр баримтлах үндсэн чиглэл, бусад материалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлэв.

Туркийн Ерөнхий сайд Р.Т.Эрдоаны энэ оны 10 дугаар сарын 4-6-нд, Люксембургийн Ерөнхий сайд Ж.К.Юнкерын 10 дугаар сарын 26-28-нд, Европын Холбооны Гадаад харилцаа, Европын хөрш орнуудын бодлогын асуудал эрхэлсэн комиссар хатагтай Б.Ферреро-Валднерын 10 дугаар сарын 25-28-нд Монгол Улсад тус тус хийх албан ёсны айлчлалын бэлтгэлийг үргэлжлүүлэн хангаж байна. Туркийн Ерөнхий сайдын айлчлалын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

Францын Үндэсний Хурлын төлөөлөгчид 9 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсоор айлчилж, энэ үеэрээ Ерөнхийлөгчид бараалхан УИХ-ын даргатай уулзав.

Норвегийн угсаа залгамжлах Ханхүү Хаакон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Сайн санааны Элчин сайдын хувиар Монгол Улсад энэ оны 11 дүгээр сарын 3-5-нд айлчлах бөгөөд бэлтгэлийг хангаж байна.

Швейцарын Холбооны Улсын парламентын дарга А.Буньон энэ оны 10 дугаар сарын 17-20-нд Монгол Улсад албаны ёсны айлчлал хийх бөгөөд бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Люксембургийн Ерөнхий сайдын айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Элчин сайд Карло Криегер манайд 9 дүгээр сарын 1-2-нд ажиллаж, түүнийг Гадаад хэргийн сайд хүлээн авч уулзав.

Унгарын Уул уурхай, геологийн албаны Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид манайд айлчлав. Айлчлалын зорилго нь 1959-1990 онд монголын нутаг дэвсгэрт хийсэн геологийн хайгуулын ажлын тайлан мэдээг монголын талд хүлээлгэн өгөх явдал байв.

Монгол-Германы БХЯ-дын 7 дугаар зөвлөлдөх уулзалт 9 дүгээр сарын 10-12-нд Улаанбаатарт амжилттай болж өнгөрөв. Германы төлөөлөгчид Гадаад Хэргийн дэд сайд, ҮАБЗ-ийн дэргэдэх ССХ-ийн захирал, БХЯ-ны удирдлагатай уулзаж, санал солилцов.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын “Байгалийн эдийн засгийн” V чуулга уулзалтад оролцох бэлтгэл ажлыг ханган хэрэгжүүлэв.

Гадаад хэргийн сайд Чехэд хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар урт хугацааны виз мэдүүлэгч иргэд ЭСЯ-ны гадаа дараалал үүсгэн хонож байгаа асуудлыг зохицуулахаар БНЧУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдыг хүлээн авч уулзав. Элчин сайд тус ЭСЯ тодорхой арга хэмжээнүүдийг авч иргэдэд шуурхай үйлчлэх боломжийг эрэлхийлж буй талаар товч танилцуулав. Тухайлбал, шуурхай үйлчилгээний 4 оронтой утас залгах, консулын хоёр дахь үйлчилгээний цонх нээн ажиллуулах зэрэг алхмуудыг авахаар болов.

2008 оны 9 дүгээр сарын 15-19-нд болсон Монгол-Орос-Хятадын ГХЯ-дын улс төрийн газруудын захирал нарын 3 талын ээлжит зөвлөлдөх уулзалтын бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэв.

Казакстаны ЭСЯ-наас тавьсан саналын дагуу ирэх 10 дугаар сарын эхээр Казакстаны соёлын өдрүүдийг Монголд зохион байгуулах асуудлаар БСШУЯ-ны холбогдох хүмүүстэй ярьж, албан тоот хүргүүлэв.

Монгол, Казакстаны ЗГХК-ын хуралдааны үеэр яригдаж байсан, БНКазакстан Улсаас Монголд түүхий нефть болон нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэх тухай санамж бичиг байгуулах асуудлын тухай, Дэлхийн хүнсний хямрал Монгол Улсад хэрхэн нөлөөлж байгаа талаар мэдээлэл авах тухай, Казакстаны нийслэл Астана болон Монголын нийслэл Улаанбаатар хотуудын хооронд түншлэлийн харилцаа тогтоох тухай санамж бичгийн төсөл, Казахстаны “Kazyna Capital Management” хувьцаат нийгэмлэгээс илгээсэн мэдээлэл зэргийг Казахстаны ЭСЯ-наас ноотоор ирүүлснийг холбогдох яам, газруудад хүргүүлэв.

Алматын Үйл ажиллагааны хөтөлбөрийн Дунд хугацааны биелэлтийн тухай НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаас гаргах баримт бичгийн төслийг хэлэлцэх албан бус зөвлөлдөөнд оролцох төлөөлөгчдөд далайд гарцгүй орнуудын асуудлаар судалгааны төв байгуулах тухай Ерөнхийлөгчийн санаачилгыг урагшлуулах заалт оруулах заавар өгч, холбогдох үг хэллэгийг боловсруулан тусгуулав.

Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2008 оны эхний хагас жилийн биелэлтийн тайланг бэлтгэв.

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа Оросын Холбооны Улсын өмчлөлийн зарим үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын Засгийн газарт үнэ төлбөргүйгээр шилжүүлэх тухай ОХУ-ын Засгийн газраас захирамж гаргасан тухай Төрийн өмчийн хороо, Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт мэдэгдэв. Мөн Баянзүрх дүүргийн нутагт байрлах ОХУ-ын өмчлөлд байгаа 7 байрыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хүлээлцэх актын төсөлд өгсөн саналын талаар ноот боловсруулж, ОХУ-ын ЭСЯ-ны зөвлөх В.В. Кулаковт гардуулав.

#### **Батлан хамгаалах салбарт:**

“Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний “Дархан-1” энхийг сахиулах ажиллагааны хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах тухай” асуудлыг Засгийн газрын 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

БНЭУ-д болох “Нүүдэлчин заан-2008” Энэтхэг-Монголын цэргийн тусгай хүчний хамтарсан хээрийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн баг оролцуулах тухай асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“Хааны эрэлд- 2008” Олон улсын хамтарсан энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургалт дадлага 2008 оны 9 дүгээр сарын 4-22-ны өдрүүдэд Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд болж Ази, Номхон далайн бүс нутгийн 5 орны 360 гаруй цэргийн албан хаагчид оролцлоо.

Мөн “Монгол Улс, ОХУ-ын хамтарсан сургуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын тухай” асуудлыг Засгийн газрын 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Улсын Их Хурлын 1998 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”-д өөрчлөлт оруулах төсөл болон “Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг эцэслэн боловсруулж сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Дайчилгааны тухай хуулийн дагуу дайчилгааны 1, 2 дугаар зэргийн бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулах ажлыг бодлогын удирдамжаар ханган ажиллалаа.

Мөн Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөнд улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар дахь гол үзүүлэлтүүдийг 2006 оны статистикийн мэдээлэлтэй харьцуулан дүгнэлт хийх ажлыг эхлүүлэх, шаардлагатай мэдээллийг холбогдох яамдаас авах ажил үргэлжлэн хийгдэж байна.

Монгол Улс, БНХАУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх 3 дугаар уулзалт, Монгол Улс, ХБНГУ-ын Батлан яамд хоорондын зөвлөлдөх 7 дугаар уулзалтуудыг зохион байгууллаа.

Батлан хамгаалах салбарт Төрийн өмчийн үзлэг, тооллого явуулсан дүнг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох материалыг Улсын тооллогын комисст хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах Ми-171 нисдэг тэрэгний 2 дахь ээлжийг хүлээн авах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, 2 дахь ээлжийн Ми-171 загварын нэг нисдэг тэргийг хүлээн ажлын хэсэг ОХУ руу явлаа.

Монгол Улсын зарим нутаг дэвсгэрт тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайн илрүүлж, аюулгүй болгох тухай асуудлаар Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Малайз улсаас худалдан авсан хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штаб, Батлан хамгаалахын их сургуульд хүлээлгэн өглөө.

Батлан хамгаалах салбарын 2008 оны хэрэгцээнд урсгал төсвийн зардлаар худалдан авах цэргийн албан хаагчдын тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахаар зарласан тендерийг үнэлж, захиалагч байгууллагуудад бэлтгэн нийлүүлэх зөвлөмж хүргүүлсэн.

Батлан хамгаалах салбарын 2009-2011 оны төсвийн төслийг төсвийн хязгаарт үндэслэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлэн хянуулж байна.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын баталсан удирдамжийн дагуу Зэвсэгт хүчний 089, 124, 314 дүгээр ангиудын байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалган туслах ажлыг зохион байгуулж, цаашид авах арга хэмжээг тодорхойллоо.

“Дайны болон тайван цагийн үед Зэвсэгт хүчнийг дэлгэх бүдүүвч”-ийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид өргөн барьж батлууллаа.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй нэгдсэн дадлагыг “Бөөнөөр дүрвэн орсон гаднын дүрвэгсдийн хөдөлгөөнийг хилийн бүсэд хязгаарлан тогтоож, хилийн халдашгүй дархан байдлыг хангах үед улсын хилийн хамгаалалтад дэмжлэг үзүүлэх ЗХЖШ-ын ажиллагаа”, Зэвсэгт хүчний 327 дугаар ангитай “Мото буудлагын бригадын үндсэн төрлийн байлдааны үед өндөр цэцтэй зэвсэг, ҮОХЭХ хамгаалалтыг зохион байгуулах нь” сэдвээр тус тус зохион байгуулж явууллаа.

Зэвсэгт хүчний 2007-2008 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай өөрийгөө хөгжүүлэх сургалт, гэрээт цэргийн 1, 2 дугаар жилийн цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салбарын жигдрэлтийг хангах, сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын цугларалтыг “Цэргийн сургалт бэлтгэлийн шинэ тогтолцоо ба сургалтын менежмент” сэдвээр 2008 оны 9 дүгээр 28-наас 10 дугаар сарын 2-ны өрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн сургуулийн төвийг Зэвсэгт хүчинд мөрдөгдөж байгаа буудлагын шинэчилсэн курсын дагуу ерөнхий цэргийн буудлагын талбайг бэлтгэж, БК-89-д заагдсан танкийн буудлагын дасгалуудыг боловсруулах боломжтой болгохоор тоног төхөөрөмж, талбайн монтажуудыг сэргээн засварлаж байна.

ОХУ-ын Сибирийн цэргийн тойргийн бага мэргэжилтэн бэлтгэх дамжаанд 29 ахлагчийг ерөнхий цэрэг, танк, артиллер, агаарын довтолгооноос хамгаалахын мэргэжлээр суралцуулах ажлыг зохион байгууллаа.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор БХИС-ийн Ахлагчийн сургуулийн хөтөлбөрөөр 320 ахлагчийг шаардлагатай мэргэжлээр сургаж бэлтгэх ажлын хүрээнд мэргэжлийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 013 дугаар ангид зохион байгуулж байна.

Монгол, Туркийн цэргийн албан хаагчдын хамтарсан “Нүүдэлчин дайчид-2008” тусгай хүчний хээрийн сургалт, дадлагад Туркийн тал оролцох боломжгүй болсон тул уг сургалтыг Зэвсэгт хүчний тусгай томилгоот бүрэлдэхүүний тусгай үүргийн хээрийн сургалт, дадлага болгон зохион байгуулж байна.

Улаанбаатар цэргийн хүрээний 9 анги, байгууллага, Зэвсэгт хүчний 013 дугаар ангид мэргэжлийн бэлтгэл хийж байгаа Ахлагчийн сургуулийн бие бүрэлдэхүүний цэргийн албаны зохион байгуулалт, сахилга дэг журам, харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт, эрүүл мэнд, ахуй хангалтын байдлыг шалган туслав.

### **Хууль зүйн чиглэлээр:**

“Тыва улсын Засгийн газрын даргын айлчлалд санал авах тухай”, “Дархан-1 Энхийг сахиулах ажиллагааны тухай”, “Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрмийн төсөлд санал авах тухай”, “Шуудангийн талаарх зарим асуудлын тухай”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн анхны хувилбарт санал авах тухай”, “Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв байгуулах тухай”, “Хөрөнгө гаргах тухай”, “Тогтоолын заалт хүчингүй болгуулах тухай”, “Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчид олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай” зэрэг Засгийн газрын нийт 33 шийдвэрийн төсөлд санал өглөө.

Хуульчдын сонгон шалгаруулалтыг 2008 оны 8 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Сонгон шалгаруулалтанд нийт 525 оролцогч бүртгүүлснээс 464 оролцогч шалгалтанд орж урьдчилсан байдлаар 130 хүн тэнцээд байна.

Ерөнхий сайдын 2007 оны 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд 2008 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийг “Нээлттэй өдөр” болгон зохион байгуулав.

Энэ өдөр яамны газар, хэлтэс, харъяа агентлаг байгууллагуудын хэмжээнд иргэдэд зориулсан үйлчилгээг нэг цэгээс үзүүлэн ажиллав. Үүнд: Иргэний бүртгэл, мэдээллийн ажилтнууд иргэний үнэмлэх болон гадаад паспортын үйлчилгээ, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанаас зөвшөөрөл, визийн үйлчилгээний талаар мэдээлэл, гарын авлага тараасан бөгөөд Хууль зүйн үндэсний төвөөс хууль зүйн зөвлөгөө өгч, хорих ангид ял эдэлж буй хүмүүстэй ар гэрийнхнийг нь утсаар яриулж, тус арга хэмжээний үеэр давхардсан тоогоор нийт 218 иргэн үйлчлүүлээ.

Нээлттэй өдрийн хүрээнд Нотариатын танхимын нотариатч нар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж, Өмгөөлөгчдийн холбоо хууль зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд уг арга хэмжээний талаар Үндэсний олон нийтийн телевиз, TV9, UBS, Eagle, TV5 телевизээр сурвалжлага, мэдээ явуулан “Өнөөдөр сонин”, “Зууны мэдээ” сонинууд болон богино долгионы радиогоор сурталчлав.

Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт нийт 15-ыг хянаж, улсын бүртгэлд 6-г бүртгэж, 9-г буцаасан болно. Мөн энэ чиглэлээр дүгнэлт 3, лавлагаа 30-ыг өгөв.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 8, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 2, шашны байгууллага 3, төрийн бус байгууллага 87-г улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгон, 8 байгууллагын улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулав.

Тайлангийн хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн орох 1766, орох гарах 45, олон удаагийн 130, нийт 1941 гадаадын иргэнд олгох визийн зөвшөөрлийг Гадаад хэргийн яамны консулын газарт өгч, гарах-орох 669, гарах 3211, олон удаагийн 1 жилийн 290, 6 сарын 152, нийт 4322 виз олгосон.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 31 орны 502 иргэнд “Захиргааны хариуцлагын тухай” хуульд заасны дагуу 104 сая 50 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна.

Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 113 байгууллага, аж ахуйн нэгжид нийт 96 сая 400 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулан улсын орлогод оруулсан байна.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР